



# БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТИЙН НЭГДСЭН ТАЙЛАН

---

# 2019–2023



УЛААНБААТАР ХОТ  
2026 ОН

## РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

### Зохиогчид:

- Э.Номиундарь – Био–Анагаахын мэргэжилтэн, ХӨСҮТ
- Т.Хосбаяр – Төслийн зөвлөх, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
- Т.Одгэрэл – Бактериологийн лавлагаа лабораторийн тасгийн эрхлэгч, ХӨСҮТ
- Б.Бумдэлгэр – Нэгдсэн лабораторийн албаны дарга, ХӨСҮТ

### Хянан тохиолдуулсан:

- С.Энхболд– Ерөнхий захирал, ХӨСҮТ
- Б.Азжаргал – Тандалт сэргийлэлт эрхэлсэн дэд захирал, ХӨСҮТ
- О.Батбаяр – Эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа эрхэлсэн албаны дарга, ХӨСҮТ
- Ёом Жүн Соб (Yeom Joop Sop) – MIRACLE төслийн удирдагч, Ёнсэй Их Сургууль
- И Хёг Мин (Lee Hyuk Min) – MIRACLE төслийн зөвлөх, Ёнсэй Их Сургууль
- И Еэ Жү (Lee Ye Joo) – MIRACLE төслийн менежер, Ёнсэй Их Сургууль

### Дэмжиж оролцсон:

- Д.Лхагвадорж – Био–Анагаахын мэргэжилтэн, ХӨСҮТ
- Ц.Гэрэлмаа – Био–Анагаахын мэргэжилтэн, ХӨСҮТ
- Ч.Бадамцэрэн – Био–Анагаахын мэргэжилтэн, ХӨСҮТ
- Ц.Мөнх–Од – Эмнэлзүйн эмгэг судлаач, ХӨСҮТ
- Пак Да Е (Park Da Yea) – MIRACLE төслийн менежер, Ёнсэй Их Сургууль
- М.Мөнхзул – MIRACLE төслийн ажилтан
- Э.Мөнхзаяа – MIRACLE төслийн ажилтан
- Г.Эрдэнэзул – MIRACLE төслийн ажилтан

## ТАЛАРХАЛ

---

Энэхүү тайланг бэлтгэн гаргахад дэмжлэг үзүүлсэн дараах байгууллагуудад талархал илэрхийлье:

- Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам
- Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв
- ARMOR–MN тандалтын сүлжээнд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагууд
- БНСУ–ын Өвчний хяналт сэргийлэлтийн агентлаг
- БНСУ–ын Ёнсэй Их Сургууль, MIRACLE төслийн баг

Санхүүжилт: Энэхүү тайланг БНСУ–ын Өвчний хяналт, сэргийлэлтийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй MIRACLE төслийн хүрээнд бэлтгэв.

---

## МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГУУД

Тайлангийн дүн шинжилгээнд дараах эрүүл мэндийн байгууллагуудын лабораторийн мэдээллийг хамруулав. Үүнд:

- Халдварт өвчин судлалын үндэсний төв
- Улсын нэгдүгээр төв эмнэлэг
- Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг
- Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
- Хавдар судлалын үндэсний төв
- Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
- Цэргийн төв эмнэлэг
- Төмөр замын төв эмнэлэг
- Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг
- Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг
- Багануур дүүргийн эрүүл мэндийн төв
- Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв
- Налайх дүүргийн эрүүл мэндийн төв
- Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв
- Хан–Уул дүүргийн эрүүл мэндийн төв
- Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв
- Интермэд эмнэлэг
- Дорнод бүсийн оношилгоо эмчилгээний төв
- Орхон бүсийн оношилгоо эмчилгээний төв
- Ховд бүсийн оношилгоо эмчилгээний төв
- Архангай аймгийн нэгдсэн эмнэлэг
- Говь–Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг
- Говьсүмбэр аймгийн нэгдсэн эмнэлэг
- Дархан–Уул аймгийн нэгдсэн эмнэлэг
- Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг
- Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэг
- Төв аймгийн нэгдсэн эмнэлэг
- Увс аймгийн нэгдсэн эмнэлэг
- Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг



**Х**алдварт өвчин судлалын үндэсний төв ба Бүгд Найрамдах Солонгос улсын Өвчний хяналт сэргийлэлтийн агентлагтай хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсын халдварт өвчний тандалтын тогтолцоог бэхжүүлэх” төсөл нь 3 дахь жилдээ амжилттай хэрэгжиж байна. Уг төсөл нь зөвхөн ХӨСҮТ төдийгүй үндэсний хэмжээнд Халдварт өвчний хяналтын тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой төсөл юм.

Төслийн эхний зорилт болох Бичил биетний тэсвэржилт (AMR)-ийн тандалт, менежментийн чадавхыг чанарын хувьд сайжруулах зорилтын хүрээнд бид одоогоор төр хувийн хэвшлийн 16 эмнэлгийн бактериологийн лабораторийг хамруулан, ARMOR-MN сүлжээ, бичил биетний тэсвэржилт (ББТ)-ийн тандалтын тогтолцоог бий болгож, ББТ-ийн мэдээ мэдээллийг цуглуулж, анализ хийн нэгтгэж, ББТ-ийн нөхцөл байдлын тайлан мэдээг боловсруулж байна. Мөн

сүлжээ лабораториудаас өсгөвөр цуглуулж, дахин шинжилж баталгаажуулан, эргэн мэдээлж, мэргэжилтнүүдийг сургалтад хамруулж, ББТ-ийн шинжилгээний гарын авлагыг боловсруулаад байна. Төслийн хүрээнд ХӨСҮТ-ийн лабораторид ББТ-ийн тандалтад шаардлагатай орчин үеийн тоног төхөөрөмжүүд болох VITEK-2, MALDI-TOF MS, Sensititre автомат анализаторийг суурилуулсан. Мөн 2025 оны 12 сард бактерийн бүрэн геномын дараалал тодорхойлох хүчин чадал бүхий NGS шинжилгээний лабораторийг ХӨСҮТ-ийн лавлагаа лабораторид дээр шинээр байгуулж, 3 мэргэжилтнийг NGS технологи, био-информатикийн чиглэлээр БНСУ-д сургалтад хамруулсан. Эдгээр үйл ажиллагааны нийт өртөг 1.3 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Төслийн хүрээнд “ББТ-ийн 2019–2023 оны нэгдсэн тайлан”-г боловсруулж, хэвлүүлэн та бүхэнд танилцуулж байна. Энэхүү 5 жилийн дата өгөгдлийг суурь болгон ашиглаж Монгол улсын ББТ-ийн тандалтын тогтолцоог шинээр үүсгэн бий болгож, үндэсний хэмжээний ББТ-ийн тандалтын мэдээ мэдээллийг жил бүр боловсруулж тайлагнах зорилготойгоор ажиллаж байна. Дээрх үйл ажиллагаанууд нь ББТ-ээс урьдчилан сэргийлэх урт хугацааны төлөвлөгөө боловсруулахад чухал суурь нотолгоо, бодлогын бичиг баримт болох учиртай билээ.

“ББТ-ийн 2019–2023 оны нэгдсэн тайлан”-г гаргахад гар бие оролцсон, хамт боловсруулалцсан, нэгтгэн дүгнэсэн, зөвлөн тусалсан ХӨСҮТ ба ARMOR-MN сүлжээний эмч мэргэжилтнүүд, Миракл төслийн хамт олон, АШУҮИС-ийн зөвлөх дэд профессор Т.Хосбаяр, Ёнсэй Их сургуулийн Ёом Жүн Соб болон И Хёг Мин профессоруудад гүнээ талархал илэрхийлье.

2026 он 6 сар

С.Энхболд ХӨСҮТ-ийн Ерөнхий захирал, АУ-ны доктор



Сайн байна уу?

БНСУ Өвчний хяналт сэргийлэлтийн агентлагаас хэрэгжүүлж байгаа Монгол улсын халдварт өвчинд хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх ODA хөтөлбөр, MIRACLE (Mongolia Infectious disease Response and cooperation for Antimicrobial resistance and Laboratory Empowerment) project төслийн удирдагчийн хувьд Монгол улсад түүхэндээ анх удаа ‘ББТ-ийн тайлан (2019–2023)’ хэвлэгдэн гарч байгаад чин сэтгэлээсээ баяр хүргэн талархал дэвшүүлье.

Өнөөгийн цаг үед Бичил биетний тэсвэржилт (ББТ) нь хүн төрөлхтөнд заналхийлж буй “Чимээгүй цар тахал” хэмээн нэрлэгдэж байна. Ялангуяа халдварт өвчний хариу арга хэмжээнд үнэн зөв дата өгөгдөлд суурилсан тандалтын тогтолцоог бүрдүүлэх нь бодлого боловсруулах болон өвчтөний эмчилгээний үр дүнг шийдвэрлэх гол түлхүүр нь болдог. Гэвч ийм тогтолцоог бий болгох нь зөвхөн тоног төхөөрөмж суурилуулахаас гадна, стандартад нийцсэн шинжилгээний чадавх, үнэн зөв найдвартай дата өгөгдөл

цуглуулах, мөн холбогдох мэргэжилтнүүдийн уйгагүй хүчин чармайлт шаардсан урт бөгөөд амаргүй үйл явц юм. Монгол улсын Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ), БНСУ-ын Өвчний хяналт сэргийлэлтийн агентлаг (ӨХСА), мөн Ёнсэй Эрүүл мэндийн төвийн харьяа Миракл төслийн баг хамт олон өнгөрсөн 4 жилийн хугацаанд энэхүү амаргүй замыг хамтдаа туулж ирсэн билээ. Миракл төслийн хүрээнд ХӨСҮТ-ийн лабораторийн чадавхыг бэхжүүлэх, МУ-д анх удаа ХӨСҮТ-ийг үндэсний зохицуулах төв болгон ARMOR-MN (Mongolia AMR Surveillance Network)-ийг байгуулсан нь өнөөдрийн энэхүү тайлангаар бодит үр дүнг харж болно.

Энэхүү тайлан нь 2019 оноос 2023 он хүртэлх хугацаанд Монгол улсын эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлзүйн сорьцоос өсгөвөрлөсөн бактерийн антибиотикийн тэсвэржилтийн мэдээллийг нэгтгэн багтаасан болно. Энэ нь МУ-ын Эрүүл мэндийн салбарын түүхэнд анх удаа үндэсний хэмжээнд ББТ-ийн өнөөгийн байдлыг бодитоор үнэлж, МУ-ын ард иргэдийн амь насыг хамгаалах шинжлэх ухаанд суурилсан нотолгоо бүрдсэнийг илэрхийлж болно. Энэ чухал тайланг бүтээхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, харамгүй дэмжлэг туслалцаа үзүүлсэн хоёр улсын төрийн байгууллагын холбогдох албан тушаалтнууд, мөн тайлан боловсруулахад хүчин чармайлт гаргасан ХӨСҮТ болон хамтран оролцсон эмнэлгүүдийн нийт хамт олонд гүн талархсанаа илэрхийлье.

Одоо бид өнгөрсөн 5 жилийн дата өгөгдлийг суурь болгон, МУ-ын ББТ-ийн тандалтын тогтолцоог улам боловсронгуй болгож илүү нарийвчлалтай чанартай үндэсний хэмжээний ББТ-ийн тандалтын мэдээлэл боловсруулах дараагийн шатанд шилжиж байна. Энэ тайлан нь МУ-ын Эрүүл мэндийн салбарын хөгжлийн нэгэн чухал түүх болж, “Нэг эрүүл мэнд (One Health)”-ийн зарчимд тулгуурласан уялдаа холбоотой, нэгдсэн хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд түлхэц болно гэдэгт итгэлтэй байна.

2026 он 6 сар  
Миракл төслийн удирдагч: Ёом Жүн Соб



**Б**үгд Найрамдах Солонгос улсын Өвчний хяналт сэргийлэлтийн агентлаг болон Монгол улсын Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсын халдварт өвчний тандалтын тогтолцоог бэхжүүлэх” төсөл 13.5 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр 2023 оны 6–р сараас 2027 оны 12–р сарын 31–ний хооронд хоёр чиглэлээр хэрэгжиж байна.

Эхний чиглэл Монгол улсын эрүүл мэндийн аюулгүй байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг болох ББТ–ийн тандалт,

менежментийн чадавхыг сайжруулах зорилтын хүрээнд ББТ–ийн тандалтын тогтолцоог бий болгох, шинжилгээний гарын авлагыг боловсруулах, шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж оношлуураар хангах, мөн хүний нөөцийг сургаж чадавхжуулах ажлууд хийгдэж байгаа билээ.

БНСУ–ын ББТ–ийн тандалт, менежментийн чадавхыг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн Ёнсэй их сургуулийн туршлагатай профессорууд энэхүү төслийн хэрэгжүүлэгчээр ажиллаж байгаа нь харилцан суралцахад ихээхэн дэмжлэг болж байна.

Төслийн хоёрдох чиглэл болох халдварт өвчний хариу арга хэмжээ ба бэлэн байдлын чадавхыг сайжруулах зорилтын хүрээнд ХӨСҮТ–ийн халдварт өвчний хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх, ХӨСҮТ–ийн талбарын тархвар судлалын сургалт (FETP)–ын мэргэшсэн сургагч багш бэлтгэх ажлууд хийгдэж байна.

Энэхүү төсөл нь манай улсад 2026 оны 5 сард байгуулагдах Өвчний хяналт сэргийлэлтийн үндэсний төвийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох ХӨСҮТ–ийн хүний нөөц ба лабораторийн хүчин чадлыг бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байгаа билээ.

Түүнчлэн төслийн хүрээнд ББТ–ээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой “ББТ–ийн 2019–2023 оны нэгдсэн тайлан” хэвлэгдэж байгаад баяртай байна..

2026 он 6 сар  
Б.Цэцэгсайхан ЭМЯ–ны НЭМБГ–ын дарга,  
АУ–ны доктор



Эрхэм хүндэт төлөөлөгчид өө,

Монгол улсад ББТ-ийн үндэсний тандалтын тайлан анх удаа хэвлэгдэн нийтлэгдэж буйд чин сэтгэлээсээ баяр хүргэе.

ББТ нь хүн амын эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдалд тулгамдсан асуудал үүсгэж буй тул олон улсын хамтын хүчин чармайлтаар шийдвэрлэх шаардлагатай юм.

Түүнчлэн уг асуудал нь хүн ба амьтны эрүүл мэнд төдийгүй хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлдэг тул улс орнууд хил хязгаар, салбарын ялгааг үл харгалзан нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Ийм чухал цаг үед БНСУ болон Монгол улсын хамтын ажиллагааны үр дүнд энэхүү тайланг анх удаа хэвлэн нийтэлж буй нь онцгой чухал ач холбогдолтой үйл явдал гэж үзэж байна.

Цаашид энэхүү тайлан нь Монгол улсын эрүүл мэндийн бодлого боловсруулах, судалгаа шинжилгээний ажлыг дэмжихэд үр нөлөөтэйгөөр хэрэглэгдэхээс гадна ББТ-ийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээг улам боловсронгуй болгоход бодит хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

БНСУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн агентлаг нь цаашид ч олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлж, ББТ-ийн эсрэг хариу арга хэмжээний чадавхыг нэмэгдүүлэхэд тууштай дэмжлэг үзүүлэх болно.

Эцэст нь, энэхүү тайланг хэвлэн нийтлэхэд хувь нэмэр оруулсан бүх хүмүүст гүн талархал илэрхийлье.

2026 он 6 сар  
БНСУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн агентлаг  
Төлөвлөлт, зохицуулалтын газрын дарга  
Жан Ху Ён



# АГУУЛГА

ТАЛАРХАЛ .....	i
МЭНДЧИЛГЭЭ .....	ii
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	ix
ТОВЧ ХУРААНГУЙ .....	x

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ . УДИРТГАЛ

1.1 ББТ–ийн тандалт .....	3
1.2 ББТ–ийн тандалтын тогтолцооны хууль эрх зүйн зохицуулалт .....	3
1.3 ББТ–ийн тандалтын тогтолцоог бэхжүүлэх олон улсын хамтын ажиллагаа .....	4
1.4 ББТ–ийн тандалтын ARMOR–MN сүлжээний бүтэц .....	4
1.5 ББТ–ийн тандалтын ARMOR–MN сүлжээний үйл ажиллагаа .....	5

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТАЙЛАН ГАРГАХАД АШИГЛАГДСАН МАТЕРИАЛ, АРГАЗҮЙ

2.1 Тайлангийн хүрээ, загвар .....	8
2.2 Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллага, лабораториудын ирүүлсэн мэдээ, материалууд .....	8
<i>Тайланд мэдээлэл хамруулах шалгуур</i> .....	10
<i>Тайлангаас хасах шалгуур</i> .....	10
<i>Тайлангийн хязгаарлалт</i> .....	11

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮР ДҮН (2019–2023 он)

3.1 Антибиотикт мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ хийгдсэн сорьцны төрөл .....	15
3.1.1 Цусны өсгөврийн шинжилгээ (2019–2023 он) .....	15
3.1.2 Тархи нугасны шингэний өсгөврийн шинжилгээ (2019–2023 он) .....	16
3.1.3 Шээсний өсгөврийн шинжилгээ (2019–2023 он) .....	18
3.1.4 Өтгөний өсгөврийн шинжилгээ (2019–2023 он) .....	21
3.1.5 Амьсгалын доод замын өсгөврийн шинжилгээ (2019–2023 он) .....	23
3.1.6 Шархны өсгөврийн шинжилгээ (2019–2023 он) .....	24
3.2 Өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он) .....	26
3.2.1 Цусны сорьцноос өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он) .....	27
3.2.2 Тархи нугасны шингэний сорьцноос өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он) .....	28
3.2.3 Шээсний сорьцноос өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он) .....	29
3.2.4 Өтгөний сорьцноос өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он) .....	30
3.2.5 Амьсгалын доод замын сорьцны өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он) .....	31
3.2.6 Шархны сорьцноос өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он) .....	32
3.3 Эмнэлзүйн сорьцноос өсгөвөрлөсөн эмгэгтөрөгчдийн тэсвэржилт .....	33
3.3.1 <i>Staphylococcus aureus</i> –ийн антибиотикийн тэсвэржилтийн байдал (2019–2023 он) .....	33
<i>Тасгийн төрлөөр харьцуулсан дүн</i> .....	34
<i>Сорьцны төрлөөр харьцуулсан дүн</i> .....	36
<i>Өвөрмөц тэсвэржилтийн төрлөөр харьцуулсан дүн</i> .....	39

3.3.2. <i>Enterococcus faecalis</i> –ийн антибиотикийн тэсвэржилтийн байдал.....	43
Тасгийн төрлөөр харьцуулсан дүн .....	44
Сорьцны төрлөөр харьцуулсан дүн .....	47
Өвөрмөц тэсвэржилтийн төрлөөр харьцуулсан дүн.....	49
3.3.3 <i>Enterococcus faecium</i> –ийн антибиотикийн тэсвэржилтийн байдал .....	52
Тасгийн төрлөөр харьцуулсан дүн .....	53
Сорьцны төрлөөр харьцуулсан дүн .....	55
Өвөрмөц тэсвэржилтийн төрлөөр харьцуулсан дүн.....	58
3.3.4 <i>Streptococcus pneumoniae</i> –ийн антибиотикийн тэсвэржилтийн байдал (2019–2023 он).....	62
3.3.5 <i>Escherichia coli</i> –ийн антибиотикийн тэсвэржилтийн байдал.....	63
Тасгийн төрлөөр харьцуулсан дүн .....	64
Сорьцны төрлөөр харьцуулсан дүн .....	67
Өвөрмөц тэсвэржилтийн төрлөөр харьцуулсан дүн.....	69
3.3.6. <i>Klebsiella pneumoniae</i> –ийн антибиотикийн тэсвэржилтийн байдал .....	82
Тасгийн төрлөөр харьцуулсан дүн .....	83
Сорьцны төрлөөр харьцуулсан дүн .....	85
Өвөрмөц тэсвэржилтийн төрлөөр харьцуулсан дүн.....	87
3.3.7 <i>Acinetobacter spp</i> –ийн тэсвэржилтийн байдал (2019–2023 он).....	99
Тасгийн төрлөөр харьцуулсан дүн .....	100
Сорьцны төрлөөр харьцуулсан дүн .....	103
Өвөрмөц тэсвэржилтийн төрлөөр харьцуулсан дүн.....	104
3.3.8 <i>Pseudomonas aeruginosa</i> –ийн тэсвэржилтийн байдал (2019–2023 он).....	111
Тасгийн төрлөөр харьцуулсан дүн .....	112
Сорьцны төрлөөр харьцуулсан дүн .....	114
Өвөрмөц тэсвэржилтийн төрлөөр харьцуулсан дүн.....	115
3.3.9 <i>Salmonella spp</i> –ийн антибиотикийн тэсвэржилтийн байдал (2019–2023 он).....	122
Тасгийн төрлөөр харьцуулсан дүн .....	123
Сорьцны төрлөөр харьцуулсан дүн .....	125
Өвөрмөц тэсвэржилтийн төрлөөр харьцуулсан дүн.....	125
3.3.10 <i>Shigella spp</i> –ийн антибиотикийн тэсвэржилтийн байдал (2019–2023 он).....	128
Өвөрмөц тэсвэржилтийн төрлөөр харьцуулсан дүн.....	131
<b>НОМ ЗҮЙ .....</b>	<b>134</b>

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<b>АДЗ</b>	Амьсгалын доод зам
<b>АМЧ</b>	Антибиотик мэдрэг чанар
<b>ББТ</b>	Бичил биетний тэсвэржилт
<b>ББТТ</b>	Бичил биетний тэсвэржилтийн тандалт
<b>ББЭЭТ</b>	Бичил биетний эсрэг эмийн тэсвэржилт
<b>БЛЛ</b>	Бактериологийн лавлагаа лаборатори
<b>БНСУ</b>	Бүгд Найрамдах Солонгос Улс
<b>БОЭТ</b>	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
<b>ВТЭ</b>	Ванкомицинд тэсвэртэй Энтерококк
<b>ДЭМБ</b>	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
<b>КТЭ</b>	Карбапенемд тэсвэртэй энтеробактери
<b>МТСА</b>	Метициллинд тэсвэртэй Стафилококкус ауриус
<b>НЛА</b>	Нэгдсэн лабораторийн алба
<b>НЭ</b>	Нэгдсэн эмнэлэг
<b>ӨУБА</b>	Өргөтгөсөн үйлдэлтэй бетта лактамаза
<b>ӨСБТ</b>	Өсөлт саатуулах бага тун
<b>ТЗТЭ</b>	Төмөр замын төв эмнэлэг
<b>ТНШ</b>	Тархи нугасны шингэн
<b>ТТАХНЭ</b>	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
<b>УНТЭ</b>	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
<b>ҮЧГҮ</b>	Үндэсний чанарын гадаад үнэлгээ
<b>ХӨСҮТ</b>	Халдварт өвчин судлалын үндэсний төв
<b>ХСҮТ</b>	Хавдар судлалын үндэсний төв
<b>ХЭТ</b>	Хэвтэн эмчлүүлэх тасаг
<b>ШУГТЭ</b>	Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг
<b>ШЯЗ</b>	Шээс ялгаруулах зам
<b>ЭЛСИ</b>	Эмнэлзүйн лабораторийн стандартын институт

<b>ЭМБ</b>	Эрүүл мэндийн байгууллага
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв
<b>ЭТҮХХ</b>	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар
<b>ЭХЭМҮТ</b>	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
<b>ЭЭТ</b>	Эрчимт эмчилгээний тасаг
<b>AMR</b>	Antimicrobial Resistance
<b>CDC</b>	Centers for Disease Control
<b>ECO</b>	<i>Escherichia coli</i>
<b>EFA</b>	<i>Enterococcus faecalis</i>
<b>EFM</b>	<i>Enterococcus faecium</i>
<b>EOC</b>	Emergency Operations Centre
<b>FETP</b>	Field Epidemiology Training Program
<b>GLASS</b>	Global Antimicrobial Resistance and Use Surveillance System
<b>HIN</b>	<i>Haemophilus Influenza</i>
<b>HLAR</b>	High-Level Aminoglycoside Resistance
<b>KDCA</b>	Korea Disease Control and Prevention Agency
<b>KPN</b>	<i>Klebsiella pneumoniae</i>
<b>MDR</b>	Multi-Drug Resistance
<b>MRSA</b>	Methicillin-resistant <i>Staphylococcus aureus</i>
<b>NME</b>	<i>Neisseria meningitidis</i>
<b>PAE</b>	<i>Pseudomonas aeruginosa</i>
<b>PDR</b>	Pan Drug Resistance
<b>SAL</b>	<i>Salmonella spp</i>
<b>SAU</b>	<i>Staphylococcus aureus</i>
<b>SHI</b>	<i>Shigella spp</i>
<b>SPN</b>	<i>Streptococcus pneumoniae</i>
<b>WHO</b>	World Health Organization
<b>XDR</b>	eXtensively Drug Resistant

Энэхүү тайлан нь 2019–2023 оны хугацаанд Монгол улсын 29 эрүүл мэндийн байгууллагын лабораторид хийгдсэн шинжилгээний мэдээллийг цуглуулан, ретроспектив аргаар шинжилсэн антибиотикт тэсвэржилтийн тандалтын үр дүн болно. Тандалтад хамруулах бактерийн төрөл зүйлийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын GLASS тандалтын удирдамж болон Монгол улсын халдварт өвчний өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан сонгосон бөгөөд үүнд *Staphylococcus aureus*, *Enterococcus faecalis*, *Enterococcus faecium*, *Streptococcus pneumoniae*, *Escherichia coli*, *Klebsiella pneumoniae*, *Pseudomonas aeruginosa*, *Acinetobacter baumannii* комплекс, *Salmonella spp*, болон *Shigella spp*-ийг хамруулсан.

Мөн цус, шээс, өтгөний сорьцоос гадна тархи нугасны шингэн, амьсгалын доод замын сорьц (цэр), шархны сорьц зэрэг төрөл бүрийн эмнэлзүйн сорьцоос ялгасан омгуудын мэдээллийг нэгтгэв. Антибиотикт мэдрэг чанарын шинжилгээний үр дүнг тухайн лабораторид мөрдөгдөж байсан Эмнэлзүйн Лабораторийн Стандартын институт (ЭЛСИ)-ийн тайлбарлах шалгуурын дагуу үнэлсэн болно (Clinical and Laboratory Standards Institute. *Performance Standards for Antimicrobial Susceptibility Testing*, CLSI supplement M100).

Шинжилгээний дүнгээс үзэхэд, 2019–2023 оны хугацаанд 29 эрүүл мэндийн байгууллагын нийт 73,080 сорьцоос эмгэгтөрөгч бактери өсгөвөрлөгдсөн байна. Тасгийн ангиллаар авч үзвэл, амбулаторийн үйлчлүүлэгчээс 51.1% (37 393 тохиолдол), эрчимт эмчилгээнээс бусад тасгийн ХЭТ-аас 44.9% (32 809 тохиолдол), ЭЭТ-аас 4.0% (2 878 тохиолдол) тус тус бүртгэгджээ.

Өсгөвөрлөгдсөн бактерийн дотор *E. coli* 42.1% (30 792 тохиолдол)-аар хамгийн өндөр хувь эзэлсэн бол *S. aureus* 41.3% (30 188 тохиолдол)-ийг эзэлж, эдгээр хоёр бактери нийт илэрсэн бактерийн 83.4%-ийг бүрдүүлсэн байна.

Амбулаторийн сорьцод *E. coli* хамгийн түгээмэл буюу 20 251 тохиолдол илэрсэн бөгөөд энэ нь амбулаторийн нийт үүсгэгчийн 54.1%-ийг эзэлж, ихэвчлэн шээснээс өсгөвөрлөгдсөн байна. Харин хэвтэн эмчлүүлэгчдийн дунд *S. aureus* 16 294 тохиолдлоор, *Shigella spp* 2 698 тохиолдлоор

хамгийн өндөр хувьтай бүртгэгджээ. *S. aureus* нь ихэвчлэн шархны арчдаснаас өсгөвөрлөгдсөнтэй холбоотойгоор хэвтэн эмчлүүлэгчдийн дунд өндөр хувьтай байна. Эрчимт эмчилгээний тасагт *A. baumannii*-ийн халдварын 576 тохиолдол бүртгэгдэж байгаа нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын чухал үүсгэгчийн нэг болохыг илтгэж байна.

2019–2023 оны хугацаанд хийгдсэн антибиотикт мэдрэг чанарын шинжилгээний үр дүнг шинжлэхэд Монгол улсад илэрч буй гол эмгэгтөрөгчдийн антибиотикийн тэсвэржилт ноцтой түвшинд хүрсэн бөгөөд бичил биетний тэсвэржилттэй тэмцэх бодлогыг эрчимжүүлэх шаардлагатай нь харагдаж байна. 2023 оны байдлаар Монгол улсад эмнэлзүйн сорьцоос өсгөвөрлөгдсөн гол бактерийн олон эмэнд тэсвэртэй омгийн эзлэх хувь дараах байдалтай байв. Үүнд: метициллин тэсвэртэй *S. aureus* (MRSA) 71.7–84.3%, өргөтгөсөн үйлдэлтэй цефалоспорин буюу цефотаксимд тэсвэртэй *E. coli* 30.6% байна. Түүнчлэн БНСУ-д мөн тулгамдсан асуудал болоод буй карбапенемд тэсвэртэй омгуудын хувь *K. pneumoniae*-д 13.5–17.1%, *P. aeruginosa*-д 12.0–19.6%, *A. baumannii* комплексд 57.5–58.2% байв. Олон эмэнд тэсвэртэй зарим омог нь шинжилгээнд хамруулсан бүх антибиотикт тэсвэртэй байсан бөгөөд шархнаас өсгөвөрлөсөн *S. aureus*-ийн 3%, *K. pneumoniae*-ийн 13.7%, шээснээс өсгөвөрлөсөн *E. coli*-ийн 14.7% мэдрэг чанарыг тодорхойлсон бүх антибиотикт тэсвэртэй байв. Мөн сүүлийн жилүүдэд дэлхий дахинд нэмэгдэж, нийгмийн эрүүл мэндэд ноцтой заналхийлэл болж буй өргөтгөсөн үйлдэлтэй цефалоспоринд тэсвэртэй *Shigella spp*-ийн хувь 2023 онд 23.4% хүрсэн байна.

Монгол улсад антибиотикийн тэсвэржилт, ялангуяа гол эмгэгтөрөгчдийн MDR (олон эмэнд тэсвэртэй), XDR (хэт олон эмэнд тэсвэртэй), PDR (бүх эмэнд тэсвэртэй) омгуудын эзлэх хувь өссөөр байгаа нь эмчилгээнд хэрэглэх боломжтой антибиотикийн сонголт улам хязгаарлагдаж байгааг харуулж байна. Иймд бичил биетний тэсвэржилттэй тэмцэх хөтөлбөр, халдварын сэргийлэлт, хяналтын тогтолцоог бэхжүүлэх, мөн тандалтын тогтолцоог тасралтгүй сайжруулах нь нэн чухал байна.

01

УДИРТГАЛ

01



## 1.1 ББТ-ийн тандалт

Бичил биетний тэсвэржилт (ББТ) нь дэлхий дахинд нийтийн хүн амын эрүүл мэндэд томоохон аюул учруулж байгаа тулгамдсан 10 хүчин зүйлийн нэг болж тодорхойлогдсон бөгөөд антибиотик эмчилгээний үр нөлөөг бууруулснаар халдварын эмийн эмчилгээнд сонголтгүй болох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

ББТ-ийн тандалтын тогтолцоо нь эмэнд тэсвэртэй бичил биетний тархалт, үүгэгчийн онцлог, бичил биетний эсрэг эмийн тэсвэржилтийн нөхцөл байдлыг тодорхойлох, нэгтгэн дүгнэх, тайлагнах тогтолцоо юм.

ББТ-ийн тандалтын дэлхийн GLASS сүлжээнд 127 гаруй улс орнууд нэгдсэн бөгөөд ББТ-ийн тархалтын нэгдсэн дүгнэлт гаргах, дарамтыг бууруулах, хариу арга хэмжээг сайжруулах, тэсвэржилтээс урьдчилан сэргийлэхэд ахиц дэвшил гаргаж байна.

Улс орон бүр өөрийн эрүүл мэндийн салбарын бүтэц, бодлого, чиглэлд суурилан, олон улсын тандалтын тогтолцооны чиг хандлагатай уялдуулан, лабораторид суурилсан ББТ-ийн тандалтын тогтолцоог бэхжүүлэх нь хүн амын дунд болон эмнэлгийн орчин дахь эмэнд тэсвэржсэн бичил биетнийг илрүүлэх, баталгаажуулах, халдварыг таслан зогсоох, хариу арга хэмжээ авах өвчлөл, нас баралт болон эдийн засгийн дарамтыг бууруулах зэрэг өргөн хүрээний ач холбогдолтой юм.

Монгол улсын эрүүл мэндийн яам нь хууль эрх зүйн хүрээнд ББТ-ийн тандалтын тогтолцоог зохицуулах, бодлогын хэрэгжилтийг хангах үндсэн чиг үүрэгтэй. ХӨСҮТ нь ББТ-ийн тандалтын тогтолцооны үндэсний зохицуулагч бөгөөд ХӨСҮТ-ийн НЛА-ны бактериологийн лавлагаа лаборатори (БЛЛ) нь үндэсний хэмжээнд лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэж байна. Тус лаборатори ББТ-ийн тандалтын тайланг гаргаж, бодлого боловсруулагчдад шаардлагатай нотолгоонд суурилсан мэдээллээр хангах зорилго тавин ажиллаж байна.

Лабораторид суурилсан ББТ-ийн тандалтын тогтолцооны зорилтууд:

- Халдварт өвчний үүсгэгчийг илрүүлж, чанартай дэвшилтэт аргаар баталгаажуулах;

- Геномын дараалал тогтоох аргаар үүсгэгчийн хэв шинж, хувилбарыг тодорхойлох;
- ББТ-ийн тандалтын сүлжээг байгуулж, эрүүл мэндийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэн, өргөжүүлэх;
- Халдварт өвчин гарсан цаг хугацаа, газар зүйн тархалт, гарал үүсэл, харилцан хамаарлыг тодорхойлох;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын үүсгэгчийг илрүүлж, гарал эх уурхай, харилцан уялдаа, холбоог тогтоох;
- Эмийн зохистой хэрэглээг сайжруулах;
- ББТ-ийн тархалтыг тогтмол хянах, өвөрмөц тэсвэржилтийг илрүүлэх, мэдээлэх;
- Эмэнд тэсвэржсэн бичил биетний халдварын дэгдэлтийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай оновчтой авах мэдээллээр хангах;
- Эмчилгээний удирдамж, урьдчилан сэргийлэх тактик, үндэсний бодлого, стратеги боловсруулахад шаардлагатай мэдээлэл, нотолгоог бүрдүүлэх.

Тусгай зорилт:

- Лабораторийн оношилгооны чадавхыг үе шаттайгаар сайжруулах;
- Сүлжээний лабораториуд нэг стандарт аргачлалаар шинжилгээ хийж, баталгаажуулах;
- Дата мэдээлэл тогтмол цуглуулан, боловсруулж, тайлагнах;
- Бактериологийн лабораторийн шинжилгээний үр дүнг эмнэлзүйтэй холбон, ББТ-ийг зөв үнэлэх;
- Үндэсний лавлагаа болон сүлжээний лабораториудын харилцан уялдаа холбоог бэхжүүлэх;
- Лабораторид суурилсан тандалтыг тогтворжуулах;
- Мэдээллийн нэгдсэн цахим санг хөгжүүлэх;
- ББТ-ийн тандалтын дэлхийн GLASS сүлжээнд нэгдэх.

## 1.2 ББТ-ийн тандалтын тогтолцооны хууль эрх зүйн зохицуулалт

Монгол улс 2012 онд эрүүл мэндийн сайд (ЭМС)-ын 448 дугаар тушаалаар “Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмэнд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх стратеги” (2012–2016), 2017 онд ЭМС, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд (ХХААХҮС)-ын хамтарсан А/191,А/64 тушаалаар “Нянгийн тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө” (2017–2020), 2022 онд ЭМС, ХХААХҮС-ын хамтарсан

А/255,А/137 тушаалаар “ББТ-ээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө (2022–2025) зэрэг бодлогын бичиг баримтуудыг баталж, ББТ-ийн тандалтын тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байна. Цаашид 2026–гаас 2029 онд баримтлах “ББТ-ээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулахаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

### 1.3 ББТ–ийн тандалтын тогтолцоог бэхжүүлэх олон улсын хамтын ажиллагаа

ХӨСҮТ нь БНСУ–ын Өвчний хяналт, сэргийлэлтийн агентлаг (KDCA), Ёнсэй их сургуультай хамтран 2023 оноос “Монгол улсын халдварт өвчний тандалтын тогтолцоог бэхжүүлэх” МИРАКЛ төслийн хүрээнд ББТ–ийн лабораторид суурилсан тандалтын тогтолцоог хөгжүүлэх, лабораторийн чадавхыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна. Уг төсөл 2023 оны 6 дугаар сарын 26–наас 2027 оны 12 дугаар сарын 31–ний өдрийг хүртэл үргэлжилнэ.

### 1.4 ББТ–ийн тандалтын ARMOR–MN сүлжээний бүтэц

2025 онд ББТ–ийн лабораторид суурилсан тандалтын сүлжээг ARMOR–MN хэмээн нэрийдэж, тандалтын үйл ажиллагааг эхлүүлсэн ба I үе шатанд нийслэлийн 7 эмнэлгийн бактериологийн лаборатори, II үе шатанд 2026 онд нийслэлийн 8 эмнэлгийн бактериологийн лабораторийг нэмэн хамруулж, үйл ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна.


I үе шатанд хамрагдсан эмнэлгүүд:

1. Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ)
2. Улсын нэгдүгээр төв эмнэлэг (УНТЭ)
3. Улсын гуравдугаар төв эмнэлэг (УГТЭ)
4. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)
5. Чингэлтэй дүүргийн Нэгдсэн эмнэлэг (ЧДНЭ)
6. Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв (СХДЭМТ)
7. Интермед эмнэлэг (ИМЭ)

II үе шатанд хамрагдсан эмнэлгүүд:

8. Улсын хоёрдугаар төв эмнэлэг (УХТЭ)
9. Нийслэлийн амгалан амаржих газар (НААГ)
10. Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг (ТТАХНЭ)
11. Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв (БЗДЭМТ)
12. Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв (БГДЭМТ)
13. Гялс анагаах ухааны төв, (ГЯЛС АУТ)
14. Монгол–Японы эмнэлэг (МЯЭ)
15. Грандмед эмнэлэг (ГМЭ)–ийг тус тус хамрагдаад байна.

ARMOR–MN сүлжээнд хамрагдсан эмнэлгүүдийг шатлалаар ангилж үзвэл:



Зураг 1.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалын ангилал (хувиар)

Лабораторид суурилсан ББЭЭТ-ын тогтолцооны ARMOR–MN сүлжээнд хамрагдах эмнэлгүүдийг сонгохдоо ДЭМБ-ын GLASS сүлжээний дөрвөн үндсэн зарчмыг баримталсан. Үүнд:

Нэгдүгээрт: Төлөөлөх чадвар (representativeness). Эхний байдлаар нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа I, II, III шатлалын эмнэлгүүдийн лабораторийг сонгосон.

Хоёрдугаарт: Мэргэшил (specialization). Хүний нөөцийн хувьд клиник микробиологийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэнтэй бактериологийн үндсэн шинжилгээ (ялган дүйлт, АМЧ тодорхойлох) хийж буй лабораториудыг сонгосон.


Гуравдугаарт: Нутагшуулах (localization). GLASS сүлжээний тайланд ордог эмгэгтөрөгч болох *Staphylococcus aureus*, *Streptococcus pneumoniae*, *Acinetobacter baumannii*, *Pseudomonas aeruginosa*, *Escherichia coli*, *Klebsiella pneumoniae*, *Salmonella spp*, *Shigella spp*, *N. gonorrhoeae* байдаг. Үүнээс *N. gonorrhoeae*-оос бусад эмгэгтөрөгчийг хамруулахын сацуу Монгол улсын нөхцөл байдалд нийцүүлэн *Enterococcus faecalis*, *Enterococcus faecium*, *Pseudomonas aeruginosa*-ийг нэмэлтээр оруулж, өргөжүүлсэн.

Дөрөвдүгээрт: Интеграци (integration) буюу мэдээллийн уялдаа холбоог хангахын тулд WHONET программд суурилан оролцогч лабораториудаас дата цуглуулж байна.

### 1.5 ББТ-ийн тандалтын ARMOR–MN сүлжээний үйл ажиллагаа

ARMOR–MN сүлжээ нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. ББТ-ийн тандалтын тогтолцооны анхны, дунд үеийн, төгсгөлийн үнэлгээ хийх
2. ББТ-ийн тандалтын тогтолцооны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах
3. Шинжилгээний заавар, гарын авлага, зөвлөмж боловсруулах
4. Хүний нөөцийг чадваржуулах сургалтад хамруулах
5. Лабораторийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж оношлуур, дагалдах хэрэгслээр хангах
6. ЭМБ хооронд биологийн аюултай өсгөвөр болон эмнэлзүйн сорьц тээвэрлэх тогтолцоог бий болгох
7. ARMOR–MN сүлжээнд хамрагдсан ЭМБ-ын илгээсэн эмнэлзүйн омог, сорьцыг шинжлэх баталгаажуулах, эргэн мэдээллэх
8. Сүлжээнд хамрагдсан ЭМБ-ын лабораториудад шинжилгээний чанарын баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх
9. ББТ-ийн дата мэдээллийг цуглуулж, боловсруулж, анализ хийх, нэгтгэн дүгнэх, тайлагнах хэвлэн нийтлэх, танилцуулах
10. ББТ-ийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, дотоод болон олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлэн нийтлүүлэх, хурал семинарт илтгэж хэлэлцүүлэх
11. Сүлжээний уулзалтууд, форум, симпозиум зохион байгуулах
12. ББТ-ийн тандалтын тогтолцооны үйл ажиллагааны дэмжлэг хяналт хийх



Зураг 1.2 Сүлжээний бүтэц



02


ТАЙЛАН ГАРГАХАД  
АШИГЛАГДСАН  
МАТЕРИАЛ, АРГАЗҮЙ

## 2.1 Тайлангийн хүрээ, загвар

Энэхүү тайлан нь 2019 оны 1 дүгээр сарын 1–нээс 2023 оны 12 дугаар сарын 31–ний хооронд оролцогч лабораториудын шинжилгээний мэдээлэлд суурилан ретроспектив загвараар дүн шинжилгээ хийв.

Монгол улсын хэмжээнд бактериологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж ХӨСҮТ–ийн чанарын гадаад үнэлгээ (ЧГҮ)–нд хамрагдсан 64 ЭМБ–аас төрөлжсөн мэргэжлийн

төв 10, дүүргийн эрүүл мэндийн төв 6, хувийн хэвшлийн эмнэлэг 1, БОЭТ 3, аймгийн нэгдсэн эмнэлэг 9 гэх нийт 28 улсын 1 хувийн хэвшлийн эмнэлгийн бактериологийн лабораторийн дата мэдээг цуглуулан дүн шинжилгээ хийв. Тайланд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагуудыг зураг 2.1–д харуулав.



Зураг 2.1. Тайланд хамрагдсан ЭМБ

TMTЭ – Төрөлжсөн мэргэжлийн төв эмнэлэг, БОЭТ – Бүсийн оношилгоо эмчилгээний төв

## 2.2 Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллага, лабораториудын ирүүлсэн мэдээ, материалууд

Энэхүү тайланд ДЭМБ–ын GLASS аргачлалын үндсэн үзүүлэлтүүдэд нийцүүлэхийн сацуу Монгол улсын нөхцөлд нийцүүлэн цус, ТНШ, шээс, өтгөн, (бэлгийн замын сорьц ороогүй), амьсгалын доод замын сорьц, шархны сорьцноос илэрсэн *Staphylococcus aureus*, *Streptococcus pneumoniae*, *Enterococcus faecalis*, *Enterococcus faecium*, *Acinetobacter baumannii*, *Pseudomonas aeruginosa*, *Escherichia coli*, *Klebsiella pneumoniae*, *Salmonella spp*, *Shigella spp*, *Haemophilus influenzae*, *Neisseria meningitidis* зэрэг үүсгэгчийг тандалтын хүрээнд хамруулав. Нийт 6 төрлийн сорьц, 12 төрөл зүйлийн бактерийн мэдээллийг нэгтгэв. Иймд энэхүү тайлангийн зарим үзүүлэлт нь WHO GLASS –ийн үндсэн индикатор биш, харин үндэсний тандалтын тоо мэдээлэлд суурилсан үзүүлэлт болно.

Тайлант хугацаанд мэдээ ирүүлсэн ЭМБ–ууд бичил биетний төрөл зүйлийг тодорхойлохдоо уламжлалт аргаар 29 лаборатори, автомат анализатор буюу VITEK 2 compact ашигласан 22 лаборатори байв. Антибиотикт мэдрэг чанар (АМЧ) тодорхойлохдоо диск нэвчүүлэх арга ашигласан 29 лаборатори байсан бол өсөлт саатуулах бага тун (ӨСБТ)–г VITEK 2 compact анализатор ашиглан тодорхойлсон 22 лаборатори байв.

Насны ангилалыг ДЭМБ GLASS–ийн насны ангиллын дагуу бүлэглэж, тусламж үйлчилгээний төрлийг амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг (ХЭТ), эрчимт эмчилгээний тасаг (ЭЭТ) гэж ангилав. Өвчтөний эмнэлэгт хэвтсэн огноо болон сорьц авсан огнооны мэдээлэл байхгүй байсан тул ДЭМБ GLASS тандалтын сүлжээнээс зөвлөдөг шалгуурын дагуу тандаж буй үүсгэгчдийг эмнэлгийн орчны (Hospital origin) болон олон нийтийн гаралтай (Community origin) гэж ангилан тоо баримтыг гаргах боломжгүй байлаа.

Оролцогч лабораторийн тухайн үед шинжилсэн антибиотикийн нэр төрөл болон дагаж мөрдөж байсан удирдамж (CLSI M100 edition)–ийн хувилбарын нэгэн жигд байдлыг хангах боломжгүй байсан болно. Иймээс тэсвэржилтийн хувь, жил хоорондын зарим ялгаа нь бодит тархалтын өөрчлөлтөөс гадна мэдрэг чанарын хариуг дүгнэх босго утга болон тайлбарын ялгааны нөлөөнөөс үүдсэн байж болзошгүй.

Олон эмэнд тэсвэржилтийн хэв шинжийг тухайн омог тус бүрд зөвхөн шинжилсэн антибиотикийн бүлгүүдийн хүрээнд ангилсан. Иймээс өсгөвөрлөгдсөн бүх омогт бүх антибиотикийн бүлгийг хамруулан нэгэн жигд шинжлээгүй тул стандарт PDR ангилалтай шууд дүйцүүлэхгүй. Энэхүү ангиллыг олон эмийн тэсвэржилтийн харьцуулалт хийх зорилгоор ашиглалаа.

Жил, сорьц, тасаг, нас, хүйс, бичил биетний төрөл зүйлээр давтамж ба хувийг тооцсон бөгөөд жил тус бүрд шинжилсэн омгийн тоо 30–аас бага тохиолдолд тэсвэржилтийн хувийг тооцолгүй зөвхөн бодит тоон үзүүлэлт (n/N) хэлбэрээр тайлагнав.

Хүснэгт 2.1 Оролцогч лабораториудын шинжилгээний арга зүй, тоног төхөөрөмжийн тойм мэдээлэл

Бүсчлэл	Ялган дүйлт		АМЧ	
	Уламжлалт арга	Автомат анализатор	Дискээс нэвчүүлэх	ӨСБТ
<b>Улаанбаатар хот</b>				
<b>Төрөлжсөн мэргэжлийн төв эмнэлэг</b>				
Амгалан амаржих газар	√		√	
Өргөө амаржих газар	√		√	
ТЗТЭ	√		√	
ТТАХНЭ	√	√	√	√
УНТЭ	√	√	√	√
ХӨСҮТ	√	√	√	√
ХСҮТ	√	√	√	√
Цэргийн төв эмнэлэг	√	√	√	√
ШУГТЭ	√	√	√	√
ЭХЭМҮТ	√	√	√	√
<b>Дүүргийн эрүүл мэндийн төв</b>				
Багануур ЭМТ	√	√	√	√
Баянгол ЭМТ	√	√	√	√
Налайх ЭМТ	√	√	√	√
Сонгинохайрхан ЭМТ	√	√	√	√
Хан–Уул ЭМТ	√	√	√	√
Чингэлтэй ЭМТ	√	√	√	√
<b>Хувийн эмнэлэг</b>				
Интермэд эмнэлэг	√	√		√
<b>Орон нутаг</b>				
<b>Бүсийн оношилгоо эмчилгээний төв</b>				
Дорнод БОЭТ	√	√	√	√
Орхон БОЭТ	√	√	√	√
Ховд БОЭТ	√		√	
<b>Аймгийн нэгдсэн эмнэлэг</b>				
Архангай аймгийн НЭ	√	√	√	√
Говь–Алтай аймгийн НЭ	√	√	√	√
Говьсүмбэр аймгийн НЭ	√		√	
Дархан–Уул аймгийн НЭ	√	√	√	√
Дорноговь аймгийн НЭ	√	√	√	√
Сүхбаатар аймгийн НЭ	√	√	√	√
Төв аймгийн НЭ	√		√	
Увс аймгийн НЭ	√	√	√	√
Хөвсгөл аймгийн НЭ	√		√	

Хүснэгт 2.2–д сорьцны төрлөөс хамааруулан энэхүү тайлан судалгаанд хамруулсан сорьц бөгөөд бичил биетний жагсаалтыг харуулав.

Хүснэгт 2.2 Бичил биетний тэсвэржилтийн тандалт судалгаанд хамрагдах бактери болон сорьцны төрөл

Ангилал	Бактерийн төрөл, зүйл	Сорьцны төрөл					
		Цус	ТНШ	Шээс <sup>†</sup>	Өтгөн <sup>‡</sup>	АДЗ <sup>€</sup>	Шарх <sup>®</sup>
Грам зэрэг кокк	SAU ( <i>S. aureus</i> )	•	•			•	•
	SPN ( <i>S. pneumoniae</i> )	•	•			•	
	EFA ( <i>E. faecalis</i> )	•	•	•			•
	EFM ( <i>E. faecium</i> )	•	•	•			•
Грам сөрөг савханцар	ABA ( <i>A. baumannii</i> )	•	•	•		•	•
	PAE ( <i>P. aeruginosa</i> )	•	•	•		•	•
	ECO ( <i>E. coli</i> )	•	•	•		•	•
	KPN ( <i>K. pneumoniae</i> )	•	•	•		•	•
	SAL ( <i>Salmonella spp</i> )	•	•		•		
	SHI ( <i>Shigella spp</i> )				•		
	HIN ( <i>H. Influenza</i> )	•	•			•	
Грам сөрөг кокк	NME ( <i>N. meningitidis</i> )	•	•				

<sup>†</sup>Шээс – хатгаж авсан шээс, катетрийн шээс, <sup>‡</sup>Өтгөн – өтгөн болон шулуун гэдэсний арчдас, <sup>®</sup>Шарх–шарх, арьс зөөлөн эдийн арчдас, идээ, буглаа, <sup>€</sup>Амьсгалын доод замын сорьцонд энэ удаагийн тайланд зөвхөн цэрний сорьц орсон болно.

#### Тайланд мэдээлэл хамруулах шалгуур

- 2019–2023 онд ХӨСҮТ–ийн чанарын гадаад үнэлгээ (ЧГҮ)–нд хамрагдсан эрүүл мэндийн байгууллага, лаборатори байх;
- Тайлант хугацаанд цус, ТНШ, өтгөн, шарх, шээс, цэрэнд стандарт аргачлал (CLSI M100)–ын дагуу бактерийн төрөл, зүйлийг тодорхойлж, антибиотикт мэдрэг чанарыг тодорхойлсон байх;
- 2024 оны 04 сарын 01 өдрөөс 06 сарын 30–ны өдөр тогтоосон хугацаанд 2019 оны 01 сараас 2023 оны 12 сар дуустал мэдээ, материал бүрэн ирүүлсэн байх;
- Тайлангийн мэдээ, материал цуглуулах эксэл файл эсвэл түүнтэй дүйцэхүйц ББТТ–ын WHONET сүлжээний материал ирүүлсэн байх.

#### Тайлангаас хасах шалгуур

- Тайлант хугацаанд цус, ТНШ, өтгөн, шарх, шээс, цэрэнд стандарт аргачлалын дагуу бактерийн төрөл, зүйл, антибиотикт мэдрэг чанарыг тодорхойлсон боловч мэдээлэл дутуу буюу тухайлбал:
  - Бактерийн төрөл зүйл, сорьцны төрлийн мэдээлэл ирүүлсэн боловч антибиотикт мэдрэг чанарын мэдээлэл ирүүлээгүй;
  - Сорьцны төрлөөс хамааран эмгэгтөрөгч бактерийг зөв тодорхойлоогүй,
  - Бактерийн антибиотикт мэдрэг чанарыг тодорхойлоход антибиотикийг буруу сонгосон байх зэрэг орно.
- Тайлангийн хугацаанаас өөр цаг хугацаанд буюу 2019–2023 оноос өмнө эсвэл хойно цуглуулсан сорьцны мэдээллийг ирүүлсэн;
- Тайлангийн мэдээ, материал цуглуулах эксэл файл эсвэл түүнтэй дүйцэхүйц ББТТ–ын WHONET сүлжээний материал ирүүлээгүй.

Тандалт судалгаанд хамрагдсан бичил биетүүдийн АМЧ–ыг үнэлэхдээ олон улсын CLSI стандартын дагуу ДЭМБ–ын AWaRe (Access, Watch, Reserve) ангиллын дагуу бактерийн төрөл, зүйл бүрд өвөрмөц антибиотикүүдийн багцыг сонгон ашиглав.

Хүснэгт 2.3. Бактерийн төрөл, зүйл тус бүрд АМЧ-ыг тодорхойлоход ашигласан антибиотикүүдийн жагсаалт

<i>Staphylococcus aureus</i>	Penicillin, Oxacillin, Cefoxitin, Vancomycin, Gentamicin, Azithromycin or clarithromycin or erythromycin, Tetracycline, Doxycycline, Ciprofloxacin or levofloxacin, Moxifloxacin, Norfloxacin, Ofloxacin, Nitrofurantoin, Clindamycin, Trimethoprim–sulfamethoxazole, Chloramphenicol, Rifampin, Quinupristin–dalfopristin, Linezolid
<i>Streptococcus pneumoniae</i>	Penicillin, Amoxicillin–clavulanate, Cefotaxime, Ceftriaxone, Vancomycin, Erythromycin, Azithromycin, Tetracycline, Levofloxacin, Trimethoprim–sulfamethoxazole, Rifampin, Clindamycin, Linezolid
<i>Enterococcus faecalis</i>	Penicillin, Ampicillin, Vancomycin, Erythromycin, Tetracycline, Doxycycline, Ciprofloxacin, Levofloxacin, Nitrofurantoin, Rifampin, Fosfomicin, Chloramphenicol, Linezolid
<i>Enterococcus faecium</i>	Penicillin, Ampicillin, Vancomycin, Erythromycin, Tetracycline, Doxycycline, Ciprofloxacin, Levofloxacin, Nitrofurantoin, Rifampin, Fosfomicin, Chloramphenicol, Linezolid
<i>Acinetobacter baumannii</i>	Piperacillin, Ampicillin–sulbactam, Piperacillin–tazobactam, Ceftazidime, Cefepime, Cefotaxime, Ceftriaxone, Imipenem, Meropenem, Gentamycin, Tobramycin, Amikacin, Ciprofloxacin, Levofloxacin, Trimethoprim–sulfamethoxazole
<i>Pseudomonas aeruginosa</i>	Piperacillin–tazobactam, Ceftazidime, Cefepime, Aztreonam, Imipenem, Meropenem, Tobramycin, Amikacin, Ciprofloxacin, Levofloxacin
<i>Escherichia coli</i>	Ampicillin, Amoxicillin–clavulanate, Ampicillin–sulbactam, Piperacillin–tazobactam, Cefazolin, Cefepime, Cefotaxime or Ceftriaxone, Cefoxitin, Ceftazidime, Aztreonam, Ertapenem, Imipenem, Meropenem, Gentamicin, Tobramycin, Amikacin, Tetracycline, Doxycycline, Ciprofloxacin, Levofloxacin, Trimethoprim–sulfamethoxazole, Chloramphenicol, Nitrofurantoin (U)
<i>Klebsiella pneumoniae</i>	Ampicillin, Amoxicillin–clavulanate, Ampicillin–sulbactam, Piperacillin–tazobactam, Cefazolin, Cefepime, Cefotaxime or Ceftriaxone, Cefoxitin, Ceftazidime, Aztreonam, Ertapenem, Imipenem, Meropenem, Gentamicin, Tobramycin, Amikacin, Tetracycline, Doxycycline, Ciprofloxacin, Levofloxacin, Trimethoprim–sulfamethoxazole, Chloramphenicol, Nitrofurantoin (U)
<i>Salmonella spp</i>	Ampicillin, Cefotaxime or Ceftriaxone, Ertapenem, Imipenem, Meropenem, Azithromycin, Tetracycline, Ciprofloxacin, Levofloxacin, Trimethoprim–sulfamethoxazole, Chloramphenicol
<i>Shigella spp</i>	Ampicillin, Cefotaxime or Ceftriaxone, Imipenem, Meropenem, Azithromycin, Tetracycline, Doxycycline, Ciprofloxacin, Levofloxacin, Trimethoprim–sulfamethoxazole, Chloramphenicol
<i>Haemophilus influenzae</i>	Ampicillin, Amoxicillin–clavulanate, Ampicillin–sulbactam, Piperacillin–tazobactam, Cefotaxime or Ceftriaxone or Ceftazidime, Cefepime, Aztreonam, Ertapenem, Imipenem, Meropenem, Azithromycin or clarithromycin, Tetracycline, Ciprofloxacin, Levofloxacin, Moxifloxacin, Trimethoprim–sulfamethoxazole, Chloramphenicol, Rifampin
<i>Neisseria meningitidis</i>	Penicillin, Ampicillin, Cefotaxime or Ceftriaxone, Meropenem, Azithromycin, Levofloxacin, Trimethoprim–sulfamethoxazole, Chloramphenicol, Rifampin

### Тайлангийн хязгаарлалт

Энэхүү тайлан нь лабораторид суурилсан ретроспектив дүн шинжилгээ тул дараах хязгаарлалттай. Үүнд:

- Жил, сорьц, тасаг, нас, хүйс, бичил биетний төрөл зүйлээр давтамж ба хувийг тооцсон бөгөөд жил тус бүрд шинжилсэн омгийн тоо 30–аас бага тохиолдолд тэсвэржилтийн хувийг тооцолгүй зөвхөн бодит тоон үзүүлэлт (n/N) хэлбэрээр тайлагнав.
- Өвчтөний эмнэлэгт хэвтсэн огноо болон сорьц авсан огнооны мэдээлэл байхгүй байсан тул WHO GLASS тандалтын сүлжээнээс зөвлөдөг шалгуурын дагуу тандаж буй үүсгэгчдийг эмнэлгийн орчны (Hospital origin) болон олон нийтийн гаралтай (Community origin) гэж ангилан тоо баримтыг гаргах боломжгүй байлаа<sup>1</sup>.
- Орлоцгогч лабораторийн тухайн үед шинжилсэн антибиотикийн нэр төрөл болон дагаж мөрдөж байсан удирдамж (CLSI M100 edition)–ийн хувилбарын нэгэн жигд байдлыг хангах боломжгүй байсан болно. Иймээс тэсвэржилтийн хувь, жил хоорондын зарим ялгаа нь бодит тархалтын өөрчлөлтөөс гадна мэдрэг чанарын хариуг дүгнэх босго утга болон тайлбарын ялгааны нөлөөнөөс үүдсэн байж болзошгүй.
- Олон эмэнд тэсвэржилтийн хэв шинжийг тухайн омог тус бүрд зөвхөн шинжилсэн антибиотикийн бүлгүүдийн хүрээнд ангилсан. Иймээс өсгөвөрлөгдсөн бүх омогт бүх антибиотикийн бүлгийг хамруулан нэгэн жигд шинжлээгүй тул стандарт PDR ангилалтай шууд дүйцүүлэхгүй. Энэхүү ангиллыг олон эмийн тэсвэржилтийн харьцуулалт хийх зорилгоор ашиглалаа.

<sup>1</sup> Эмнэлгийн орчны (Hospital origin, HO) гэдэг ангилалд 3 болон түүнээс дээш хоног хэвтэн эмчлүүлж буй өвчтөнөөс авсан сорьц, эсвэл тухайн эмнэлэгт 3–аас дээш хоног хэвтээгүй боловч өөр эмнэлэгт 2–оос дээш хоног хэвтэн эмчлүүлээд шилжин ирсэн өвчтөнөөс авсан сорьц орно. Харин олон нийтийн гаралтай халдвар (Community origin, CO) гэдэг ангилалд 2 болон түүнээс доош хоног хэвтэн эмчлүүлсэн өвчтөнөөс авсан сорьц, эсвэл амбулаторийн өвчтөнөөс авсан сорьц багтана.

- *S. aureus*-ийн ванкомицин, клиндамициний мэдрэг чанарыг тодорхойлсон шинжилгээний үр дүн байсан хэдий ч эцсийн дүн шинжилгээнээс хассан болно. Учир нь CLSI M100 удирдамжийн дагуу ванкомициныг заавал өсөлт саатуулах бага тун (ӨСБТ буюу MIC) тодорхойлох аргаар баталгаажуулах шаардлагатай байдаг.
- Клиндамициний өдөөгддөг тэсвэржилт (Inducible clindamycin resistance)-ийг илрүүлэх “D тест”-ийн шинжилгээ хийгдсэн эсэх мэдээлэл байхгүй тул клиндамициний тэсвэржилтийн хувийг тодорхойлох боломжгүй гэж үзлээ.
- Тигециклиний үр дүнг тайлбарлахдаа болгоомжтой хандах шаардлагатай. Учир нь глицилциклиний бүлгийн антибиотикуудын (ялангуяа тигециклин) мэдрэг чанарыг диск нэвчүүлэх аргаар тодорхойлох нь зарим тохиолдолд хуурамч тэсвэртэй (false resistance) хариу гарах эрсдэл байдаг.
- Зарим сорьц болон эмгэгтөрөгчийн АМЧ тодорхойлсон тоо харьцангуй цөөн байгаа нь хувиар илэрхийлэх боломжгүй тул тоогоор харуулсан болно.
- Ховор тэсвэржилт илэрсэн тохиолдлуудыг ӨСБТ-г тодорхойлох лавлагаа аргаар (жишээ нь: шөлөнд шингэрүүлэх арга) баталгаажуулах нь үр дүнгийн үнэн зөв байдлыг хангахын тулд удирдамжийн дагуу тохиолдолд халдварын хяналтын багт мэдэгдэж, ХӨСҮТ-ийн лавлагаа лаборатори руу сорьцыг илгээн баталгаажуулах ёстой байдаг ч энэхүү шаардлага хангагдаагүй байна. Иймд цаашид эмнэлзүйн лабораториуд дээр дурдсан тохиолдлуудад шинжилгээг давтан шалгаж, өсгөврийг хадгалан холбогдох журмын дагуу лавлагаа лабораторид илгээж баталгаажуулж байхыг зөвлөж байна.

03

ҮР ДҮН  
2019–2023 он

03




### 3.1 АНТИБИОТИКТ МЭДРЭГ ЧАНАР ТОДОРХОЙЛОХ ШИНЖИЛГЭЭ ХИЙГДСЭН СОРЬЦНЫ ТӨРӨЛ

#### 3.1.1 Цусны өсгөврийн шинжилгээ (2019–2023 он)


2019–2023 оны хугацаанд нийт 797 цусны өсгөврийн шинжилгээ хийгдсэн байна. Жилээр авч үзвэл шинжилгээний тоо 2019 онд 33, 2020 онд 128, 2021 онд 209, 2022 онд 146, 2023 онд 281 байсан бөгөөд судалгааны хугацаанд өсөх хандлага ажиглагдав. Гэхдээ 2022 онд түр буурсан хэдий ч 2023 онд хамгийн олон бүртгэгдсэн байна.

Хүйсээр ангилан харьцуулахад цусны өсгөврийн шинжилгээний 46.8% (373/797) эмэгтэй, 48.4% (386/797) нь эрэгтэй байсан буюу хүйсийн харьцаа бараг ижил түвшинд байна.



Зураг 3.1–1 А. Цусны өсгөврийн шинжилгээний нийт тоо, жилээр; 1Б. Цусны өсгөврийн шинжилгээний тоо, хүйсээр харуулав.

Тасгийн төрлөөр ангилсан шинжилгээгээр цусны өсгөврийн шинжилгээний дийлэнх нь ХЭТ–т ногдож байв. ХЭТ–т жил бүрийн шинжилгээний тоо 2019 онд 20, 2020 онд 96, 2021 онд 113, 2022 онд 94, 2023 онд 215 байсан нь бүх жилд хамгийн өндөр үзүүлэлт байлаа. Харин эрчимт эмчилгээний тасагт (ICU) харгалзах үзүүлэлт 9, 26, 77, 37, 58, амбулаторийн тусламжид 4, 6, 19, 15, 8 байв. Өөрөөр хэлбэл цусны өсгөврийн шинжилгээний нийт өсөлтийг голлон ХЭТ–ийн тооны өсөлт тодорхойлж байсан бөгөөд ялангуяа 2023 онд энэ өсөлт хамгийн тод ажиглагдав. Үүний эсрэгээр амбулаторийн шинжилгээний хэмжээ бүх хугацаанд хамгийн бага хэвээр байлаа.



Зураг 3.1–2 Цусны өсгөврийн шинжилгээний тоо, тасгийн төрлөөр

Цусны өсгөврийн шинжилгээний үр дүн харьцангуй цөөн тул насны бүлгийг WHO GLASS–ын шалгуураар тооцон жил бүр ангилан тооцох боломжгүй байлаа.


Насны бүлэг болон тусламж үйлчилгээ авсан тасгийн төрлөөр ангилан үнэлэхэд, тохиолдлын дийлэнх нь ХЭТ–аас бүртгэгдсэн (538/797; 67.5%) ба ЭЭТ–ийн өвчтөнүүд (207/797; 25.9%), харин амбулаторийн тохиолдол харьцангуй цөөн (52/797; 6.5%) байв.

Хүснэгт 3.1–1 Цусны өсгөврийн эерэг тохиолдол, насны бүлгээр

Насны бүлэг	Амбулатори	ХЭТ	ЭЭТ	Нийт
<1	0	58	11	69
1–4	2	21	6	29
5–14	2	15	7	24
15–24	0	25	6	31
25–34	6	57	8	71
35–44	4	69	33	106
45–54	3	60	34	97
55–64	9	77	37	123
65–74	6	62	37	105
75–84	1	30	14	45
85<	0	3	1	4
Нас тодорхойгүй	19	61	13	93
Нийт (нас мэдэгдэж буй)	33	477	194	704
Нийт	52	538	207	797

Насны бүлгээр авч үзвэл, хамгийн олон эерэг тохиолдол 55–64 насанд бүртгэгдсэн (123; 15.4%) байна. Мөн 35–44 нас (106; 13.2%), 65–74 нас (105; 13.1%), 45–54 нас (97; 12.1%)–нд харьцангуй олон байгаа нь цусны өсгөврийн эерэг тохиолдол 35–74 насны бүлгүүдэд төвлөрсөн буюу насанд хүрсэн болон ахимаг насны өвчтөнүүдэд илүү өндөр хувиар илэрч байгааг харуулж байна.

Хүүхдийн насны бүлгүүдээс <1 насны бүлэгт эерэг тохиолдлын тоо хамгийн өндөр (69) байсан нь бага насны хүүхдүүд, ялангуяа нярай болон хөхүүл үеийн хүүхдүүдэд үжил халдварын эрсдэл эмнэлзүйн хувьд чухал хэвээр байгааг харуулж байна. Харин 1–14 насны бүлэгт тохиолдлын тоо харьцангуй бага байв.




Зураг 3.1–3 Цусны өсгөвөр эерэг тохиолдол насны бүлэг, тасгийн төрлөөр

### 3.1.2 Тархи нугасны шингэний өсгөврийн шинжилгээ (2019–2023 он)


2019–2023 оны хугацаанд нийт 47 тархи нугасны шингэн (ТНШ)–ий өсгөврийн шинжилгээ хийгдсэн байна. Жилээр авч үзвэл шинжилгээний нийт тоо 2019 онд 4, 2020 онд 12, 2021 онд 8, 2022 онд 8, 2023 онд 15 байсан бөгөөд ялангуяа 2023 онд өмнөх бүх жилээс өндөр байв.

Хүйсээр ангилан үнэлэхэд ТНШ–ий өсгөврийн шинжилгээ эмэгтэй өвчтөнүүдэд давамгайл хийгдсэн байна. Судалгааны нийт хугацаанд эмэгтэйчүүдэд 25 шинжилгээ (56%), эрэгтэйчүүдэд 20 шинжилгээ (44%), хүйс тодорхойгүй 2 тус тус хийгдсэн байна.



Зураг 3.1-4 А. ТНШ-ий өсгөврийн шинжилгээний нийт тоо, жилээр; Б. ТНШ-ий өсгөврийн шинжилгээний тоо, хүйсээр

Тасгийн төрлөөр ангилан үзэхэд ТНШ-ий өсгөврийн шинжилгээний ихэнхдээ ХЭТ-аас хийгдсэн байна. 2019–2023 онд амбулаторийн тасгаас 6 шинжилгээ (12.7%), ХЭТ-ийн 31 шинжилгээ (65.9%), ЭЭТ-ийн 10 шинжилгээ (21.2%) хийгдсэн байна.



Зураг 3.1-5 ТНШ-ий өсгөврийн шинжилгээний тоо, тасгийн төрлөөр


Нас тодорхой байсан нийт 47 ТНШ-ий өсгөврийн шинжилгээний эерэг тохиолдлыг насны бүлэг болон тусламж үйлчилгээ авсан тасгийн төрлөөр харьцуулахад дийлэнх нь ХЭТ (31/47; 65.9%), ЭЭТ-ийн өвчтөнүүд (10/47; 21.2%) байсан ба амбулаторийн тохиолдол 6 (6/47; 12.8%) байв. Нийт 47 ТНШ-ий өсгөврийн шинжилгээний эерэг тохиолдлоос 4 тохиолдолд нас тодорхойгүй байсан.

Насны бүлгээр авч үзвэл, ТНШ-ий өсгөврийн шинжилгээний эерэг тохиолдол нь цөөн тоотой боловч хамгийн олон тохиолдол <1 насны хүүхдүүдэд бүртгэгдсэн нь нярай болон бага насны хүүхдүүдийн төв мэдрэлийн тогтолцооны халдвар эмнэлзүйд тулгамдсан асуудал хэвээр байгааг харуулж байна. Насанд хүрэгчдийн насны бүлгүүдэд тохиолдол харьцангуй цөөн байв.

Хүснэгт 3.1-2 ТНШ-ний өсгөврийн эерэг тохиолдол, насны бүлгээр

Насны бүлэг	Амбулатори	ХЭТ	ЭЭТ	Нийт
<1	2	8	3	13
1–4	0	4	1	5
5–14	0	1	0	1
15–24	1	0	0	1
25–34	2	3	1	6
35–44	0	3	0	3
45–54	0	4	1	5
55–64	1	3	0	4
65–74	0	2	3	5
Нас мэдэгдэхгүй	0	3	1	4
Нийт (нас мэдэгдэж буй)	6	28	9	43
Нийт	6	31	10	47

Тусламж үйлчилгээний авсан тасгийн төрлийн хувьд ХЭТ болон ЭЭТ-ийн тохиолдол дийлэнх хувийг эзэлж байв. Энэ нь ТНШ-ний өсгөврийн шинжилгээний эерэг тохиолдлууд нь ихэвчлэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай, биеийн байдал хүнд өвчтөнүүдэд тохиолддог онцлогоос хамаарч байна.




Зураг 3.1-6 ТНШ-ний өсгөврийн шинжилгээний эерэг тохиолдол насны бүлэг, тасгийн төрлөөр

### 3.1.3 Шээсний өсгөврийн шинжилгээ (2019–2023 он)


2019–2023 оны хугацаанд нийт 31497 шээсний өсгөврийн эерэг шинжилгээ хийгдсэн байна. Жилээр авч үзвэл шинжилгээний нийт тоо 2019 онд 3584 2020 онд 5287, 2021 онд 4145, 2022 онд 5907, 2023 онд 12574 байсан бөгөөд ялангуяа 2023 онд өмнөх бүх жилээс мэдэгдэхүйц өндөр үзүүлэлттэй байсан байна.

Хүйсээр ангилан үнэлэхэд шээсний өсгөврийн шинжилгээ эмэгтэй өвчтөнүүдэд давамгайлж хийгдсэн байна. Судалгааны нийт хугацаанд эмэгтэйчүүдэд 27356 шинжилгээ (86.8%), эрэгтэйчүүдэд 3676 шинжилгээ (11.6%), хүйс тодорхойгүй 465 тус тус хийгдсэн байна.



Зураг 3.1–7 А. Шээсний өсгөврийн шинжилгээний нийт тоо, жилээр; Б. Шээсний өсгөврийн шинжилгээний нийт тоо, хүйсээр.

Тасгийн төрлөөр ангилан үзэхэд шээсний өсгөврийн шинжилгээний үндсэн ачаалал амбулаторийн тасгаас захиалагдсан байна. 2019–2023 онд амбулаторийн тасгаас 22155 шинжилгээ (70.3%), ХЭТ 8719 шинжилгээ (27.6%), ЭЭТ–ийн 623 шинжилгээ (1.9%) хийгдсэн байна.



Зураг 3.1–8 Шээсний өсгөврийн шинжилгээний тоо, тасгийн төрлөөр

2019–2023 оны хугацаанд нийт 31497 шээсний өсгөврийн эерэг тохиолдлын 29034 тохиолдолд нас тодорхой, 2463 тохиолдолд нас тодорхойгүй байв.

Насны бүлэг болон тусламж үйлчилгээ авсан тасгийн төрлөөр харьцуулахад шээсний өсгөврийн эерэг тохиолдлын дийлэнх нь амбулаторийн өвчтөнүүд 70.3% (22155/31497)–ийг эзэлж байна. Мөн ХЭТ 27.7% (8719/31497) болон ЭЭТ–ийн өвчтөнүүд 2.0% (623/31497)–ийг эзэлж байна.


Нас тодорхой тохиолдлуудын дунд хамгийн олон тохиолдол 55–64 насны бүлэгт 5495 бүртгэгдсэн бол 25–34 насанд 5413, 35–44 насанд 4907, 45–54 насанд 3925 болон 65–74 насанд 3876 тохиолдол тус тус бүртгэгдсэн. Шээсний өсгөврийн эерэг тохиолдол нь 25–74 насны насанд хүрэгчдийн бүлгүүдэд илүү их тохиолдож байна.

Хүүхдийн насны бүлгүүдэд тохиолдлын тоо харьцангуй бага байсан ч 15–24 наснаас эхлэн огцом нэмэгдэж, дунд болон ахимаг насанд өндөр хэвээр хадгалагдсан байна. Харин 75–84 нас болон 85–аас дээш насанд тохиолдлын тоо дахин буурах хандлагатай байв. <1 насны бүлэгт нийт 122 эерэг тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь нярай болон бага насны хүүхдүүдэд шээсний замын халдвар клиникийн ач холбогдолтой хэвээр байгааг харуулж байна.

Хүснэгт 3.1–3 Шээсний өсгөврийн эерэг тохиолдол, насны бүлэг, тасгийн төрлөөр

Насны бүлэг	Амбулатори	ХЭТ	ЭЭТ	Нийт
<1	35	73	14	122
1–4	180	123	8	311
5–14	235	167	7	409
15–24	1400	862	20	2282
25–34	3506	1863	44	5413
35–44	3394	1446	67	4907
45–54	2993	848	84	3925
55–64	4135	1229	131	5495
65–74	2788	961	127	3876
75–84	1238	559	70	1867
85<	249	157	21	427
Нийт (насны бүлэг тодоргүй)	2002	431	30	2463
Нийт (насны бүлэг тодорхой)	20153	8288	593	29034
Нийт	22155	8719	623	31497

Тусламж үйлчилгээ авсан тасгийн төрлийг насны бүлэг тус бүрд харьцуулахад амбулаторийн тохиолдол бүх насанд давамгайлсан байна. Ялангуяа 55–64 насанд 4135 тохиолдол, 25–34 насанд 3506 тохиолдол, 35–44 насанд 3394 тохиолдол болон 45–54 насанд 2993 тохиолдол байсан. ХЭТ-ийн тохиолдол мөн насанд хүрэгчдийн насны бүлгүүдэд харьцангуй өндөр буюу хамгийн өндөр нь 25–34 насанд 1863 тохиолдол, 35–44 насанд 1446 тохиолдол, 55–64 насанд 1229 тохиолдол болон 65–74 насанд 961 тохиолдол байв. ЭЭТ-ийн тохиолдол нийт дүнгээр бага боловч ахимаг насанд харьцангуй өндөр байсан бөгөөд 55–64 насанд 131, 65–74 насанд 127 болон 45–54 насанд 84 тохиолдол тус тус бүртгэгджээ.




Зураг 3.1–9 Шээсний өсгөврийн шинжилгээний эерэг тохиолдол, насны бүлэг, тасгийн төрлөөр

### 3.1.4 Өтгөний өсгөврийн шинжилгээ (2019–2023 он)


2019–2023 оны хугацаанд нийт 3913 өтгөний өсгөврийн шинжилгээ хийгдсэн байна. Үүнээс 3611 тохиолдолд нас тодорхой, 302 тохиолдолд нас тодорхойгүй байв. Жилээр авч үзвэл шинжилгээний нийт тоо 2019 онд 1559, 2020 онд 878, 2021 онд 161, 2022 онд 711, 2023 онд 604 байсан бөгөөд ялангуяа 2019 онд бүх жилээс мэдэгдэхүйц өндөр үзүүлэлттэй байсан байна.

Судалгааны нийт хугацаанд эмэгтэйчүүдэд 2042 шинжилгээ (52.2%), эрэгтэйчүүдэд 1758 шинжилгээ (44.9%), хүйс тодорхойгүй 113 тус тус байна. Жилээр харвал ихэнх онуудад эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс бага зэрэг өндөр байв.



Зураг 3.1–10 А. Өтгөний өсгөврийн шинжилгээний нийт тоо, жилээр; Б. Өтгөний өсгөврийн шинжилгээний нийт тоо, хүйсээр

Тасгийн төрлөөр ангилан үзэхэд өтгөний өсгөврийн шинжилгээний үндсэн ачаалал ХЭТ–аас байна. 2019–2023 онд өтгөний өсгөврийн эерэг тохиолдлын 86.0% (3365/3913) нь ХЭТ, 13.6% (532/3913) амбулаторийн өвчтөн, 0.4% (16/3913) нь ЭЭТ–ийн тохиолдол байв.




Зураг 3.1–11 Өтгөний өсгөврийн шинжилгээний тоо, тасгийн төрлөөр

Нас тодорхой тохиолдлуудын дунд 1–4 насанд 1442, 5–14 насанд 1151, <1 насанд 302, 25–34 насанд 184 болон 15–24 насанд 171 тохиолдол тус тус бүртгэгдсэн. Өтгөний өсгөврийн эерэг тохиолдол нь хүүхдийн насны бүлэг (<15 нас) хамгийн их буюу <1, 1–4, 5–14 насны бүлгүүд нас тодорхой нийт тохиолдлын 80.2%–ийг эзэлж байна. Ялангуяа 1–4 насны хүүхдүүдэд хамгийн олон эерэг тохиолдол бүртгэгдсэн нь бага насны хүүхдүүдийн гэдэсний халдварын өндөр тархалттай байгааг харуулж байна. Насанд хүрэгчдийн насны бүлгүүдэд тохиолдлын тоо харьцангуй бага байна.

Хүснэгт 3.1–4 Өтгөний өсгөврийн эерэг тохиолдол, насны бүлэг, тасгийн төрлөөр

Насны бүлэг	Амбулатори	ХЭТ	ЭЭТ	Нийт
<1	20	281	1	302
1–4	136	1304	2	1442
5–14	104	1043	4	1151
15–24	26	145		171
25–34	23	160	1	184
35–44	24	99	3	126
45–54	18	62	2	82
55–64	11	61		72
65–74	9	39		48
75–84	7	20	1	28
85<	1	3	1	5
Тодорхойгүй	153	148	1	302
Нийт (нас тодорхой)	379	3217	15	3611
Нийт	532	3365	16	3913

Тусламж үйлчилгээ авсан тасгийн төрлөөр харьцуулахад ХЭТ-ийн тохиолдол бүх насны бүлэгт давамгайлж байсан ба ялангуяа 1–4 нас (1442), 5–14 нас (1151), <1 нас (302) насны бүлгүүдэд хамгийн өндөр байв. Амбулаторийн тохиолдол мөн хүүхэд насанд бүртгэгдсэн боловч ХЭТ-ийн дүнгээс хавьгүй бага байна. ЭЭТ-ийн тохиолдол маш цөөн байлаа. Өөрөөр хэлбэл өтгөний өсгөврийн эерэг тохиолдлуудад ихэвчлэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай хүүхдийн тохиолдол давамгайлж байгааг харуулж байна.




Зураг 3.1–12 Өтгөний өсгөврийн шинжилгээний эерэг тохиолдол насны бүлэг, тасгийн төрлөөр

### 3.1.5 Амьсгалын доод замын сорьцны өсгөврийн шинжилгээ (2019–2023 он)

Амьсгалын доод зам (АДЗ)-ын бусад төрлийн сорьцны тоо баримт үгүй тул зөвхөн цэрний өсгөврийн шинжилгээний үр дүн энэ тайланд багтлаа. 2019–2023 оны хугацаанд нийт 3122 цэрний эерэг өсгөврийн шинжилгээ хийгдсэн байна.


Жилээр авч үзвэл шинжилгээний нийт тоо 2019 онд 134, 2020 онд 436, 2021 онд 833, 2022 онд 496, 2023 онд 1223 байсан бөгөөд ялангуяа 2023 онд бүх жилээс мэдэгдэхүйц өндөр үзүүлэлттэй байсан байна. Энэ нь судалгааны хугацааны цэрний өсгөврийн шинжилгээний эерэг тохиолдлын тоо нэмэгдэх хандлагатайг харуулж байна.

Хүйсээр ангилан үнэлэхэд цэрний өсгөврийн шинжилгээ эрэгтэй өвчтөнүүдэд давамгайл хийгдсэн байна. Судалгааны нийт хугацаанд эмэгтэйчүүдэд 1393 шинжилгээ (45.6%), эрэгтэйчүүдэд 1663 шинжилгээ (54.4%), хүйс тодорхойгүй 66 тус тус хийгдсэн байна.



Зураг 3.1-13 А. Цэрний өсгөврийн шинжилгээний нийт тоо, жилээр; Б. Цэрний өсгөврийн шинжилгээний нийт тоо, хүйсээр

Тасгийн төрлөөр ангилан үзэхэд цэрний өсгөврийн шинжилгээний үндсэн ачаалал ХЭТ-аас захиалагдсан байна. 2019–2023 онд амбулаторийн тасгаас 1253 шинжилгээ (40.1%), ХЭТ-ийн 1064 шинжилгээ (34.1%), ЭЭТ-ийн 805 шинжилгээ (25.8%) хийгдсэн байна.




Зураг 3.1-14 Цэрний өсгөврийн шинжилгээний тоо, тасгийн төрлөөр

Нас тодорхой тохиолдлуудын дунд амбулаторийн тохиолдол 997, ХЭТ-ийн тохиолдол 994, ЭЭТ-ийн тохиолдол 765 байна. Насны бүлгээр харьцуулан үзэхэд 55–64 насанд амбулаторийн 239, ХЭТ-ийн 263, ЭЭТ-ийн 211 тохиолдол байсан. Мөн 45–54 болон 65–74 насны бүлгүүдэд тохиолдол харьцангуй өндөр ажиглагдсан.

Хүснэгт 3.1–5 Цэрний өсгөврийн эерэг тохиолдол, насны бүлэг, тасгийн төрлөөр

Насны бүлэг	Амбулатори	ХЭТ	ЭЭТ	Нийт
<1	5	16	4	25
1–4	1	10	1	12
5–14	7	14	3	24
15–24	48	23	22	93
25–34	109	57	43	209
35–44	189	132	108	429
45–54	187	163	136	486
55–64	239	263	211	713
65–74	133	175	143	451
75–84	63	96	79	238
85<	16	45	15	76
Нас тодорхойгүй	256	70	40	366
Нийт (нас тодорхой)	997	994	765	2756
Нийт	1253	1064	805	3122

Хүүхдийн насны бүлгүүдэд цэрний өсгөврийн шинжилгээний эерэг тохиолдол харьцангуй бага байсан боловч <1 насанд 25, 1–4 насанд 12, 5–14 насанд 24 тохиолдол бүртгэгдсэн. Үүний эсрэгээр, 15 наснаас дээш насанд тохиолдлын тоо огцом нэмэгдэж, дунд болон ахимаг насанд оргил түвшинд хүрсэн байна.




Зураг 3.1–15 Цэрний өсгөврийн шинжилгээний эерэг тохиолдол насны бүлэг, тасгийн төрлөөр

### 3.1.6 Шархны өсгөврийн шинжилгээ (2019–2023 он)


2019–2023 оны хугацаанд нийт 33 704 шархны өсгөврийн эерэг тохиолдол бүртгэгдсэн.

Жилээр авч үзвэл, шархны өсгөврийн эерэг тохиолдлын тоо 2019 онд 3463, 2020 онд 8173, 2021 онд 6105, 2022 онд 5926, 2023 онд 10037 байсан бөгөөд 2023 онд хамгийн олон бүртгэгдсэн байна. 2020 онд огцом өссөн, 2021–2022 онд тодорхой хэмжээгээр буурсан боловч 2023 онд дахин мэдэгдэхүйц өссөн хэв шинж ажиглагдав.

Хүйсээр ангилан үнэлэхэд шархны өсгөврийн шинжилгээ эмэгтэй өвчтөнүүдэд давамгайл хийгдсэн байна. Судалгааны нийт хугацаанд эмэгтэйчүүдэд 17927 шинжилгээ (54.4%), эрэгтэйчүүдэд 15029 шинжилгээ (45.6%), хүйс тодорхойгүй 748 тус тус хийгдсэн байна.



Зураг 3.1–16 А. Шархны өсгөврийн шинжилгээний нийт тоо, жилээр; Б. Шархны өсгөврийн шинжилгээний нийт тоо, хүйсээр




Зураг 3.1–17 Шархны өсгөврийн шинжилгээний тоо, тасгийн төрлөөр

Тусламж үйлчилгээ авсан тасгийн төрлөөр харьцуулахад шархны өсгөврийн шинжилгээний эерэг тохиолдлын дийлэнх нь ХЭТ-аас бүртгэгдсэн 56.6% (19092/33704) байна. Харин амбулаторийн өвчтөнүүд 39.7% (13395/33704), харин ЭЭТ-ийн тохиолдол харьцангуй цөөн 3.6% (1217/33704) байв.

Хүснэгт 3.1–6. Шархны өсгөврийн эерэг тохиолдол, насны бүлэг, тасгийн төрлөөр

Насны бүлэг	Амбулатори	ХЭТ	ЭЭТ	Нийт
<1	165	1295	279	1739
1–4	1018	1960	75	3053
5–14	1473	2193	67	3733
15–24	1428	1716	69	3213
25–34	1961	3017	78	5056
35–44	1740	2711	118	4569
45–54	1674	2008	118	3800
55–64	1365	1690	174	3229
65–74	638	890	109	1637
75–84	251	427	65	743
85<	78	92	5	175
Нас тодорхойгүй	1604	1093	60	2757
Нийт (нас тодорхой)	11791	17999	1157	30947
Нийт	13395	19092	1217	33704

Тусламж үйлчилгээ авсан тасгийн төрлийн хувьд ХЭТ тохиолдол бүх насны бүлэгт давамгайлж байсан. Ялангуяа 25–34 насанд 3017, 35–44 насанд 2711, 5–14 насанд 2193, 45–54 насанд 2008, 1–4 насанд 1960 тохиолдол бүртгэгдсэн. Амбулаторийн тохиолдол мөн харьцангуй өндөр байсан бөгөөд 25–34 насанд 1961, 35–44 насанд 1740, 45–54 насанд 1674, 5–14 насанд 1473, 15–24 насанд 1428 тохиолдол тус тус бүртгэгдсэн. ЭЭТ-ийн тохиолдол нийтдээ бага хувь эзэлсэн боловч 55–64 насанд 174, 35–44 болон 45–54 насанд тус бүр 118, 65–74 насанд 109 тохиолдол бүртгэгдсэн байна.



Зураг 3.1–18 Шархны өсгөврийн шинжилгээний эерэг тохиолдол насны бүлэг, тасгийн төрлөөр

### 3.2 ӨСГӨВӨРЛӨГДСӨН ЭМГЭГТӨРӨГЧИЙН ТАРХАЛТ БА БҮТЭЦ (2019–2023 ОН)


2019–2023 оны хугацаанд эмнэлзүйн сорьцоос нийт 73080 тохиолдолд бичил биетэн өсгөвөрлөгдсөн байна. Үүнээс амбулаторийн тасгийн үйлчлүүлэгчдээс 37393 (51.1%), ХЭТ–ийн үйлчлүүлэгчдээс 32809 (44.9%), харин ЭЭТ үйлчлүүлэгчдээс 2878 (4.0%) өсгөвөрлөх шинжилгээний эерэг тохиолдол тус тус бүртгэгджээ.

Өсгөвөрлөгдсөн нийт омгийн дийлэнх хэсгийг *Escherichia coli* болон *Staphylococcus aureus* хоёр эзэлж байна. Тодруулбал: *E. coli* 30792 (42.1%), *S. aureus* 30188 тохиолдол (41.3%)–оор тус тус илэрсэн нь нийт тохиолдлын 83.4%–ийг бүрдүүлж байна. Үүний дараа *K. pneumoniae* (3536 тохиолдол) болон *Shigella spp* (3077 тохиолдол) орж байна.

Амбулаторийн сорьцоос өсгөвөрлөгдсөн омгийн дотор *E. coli* хамгийн өндөр тархалттай буюу 20251 тохиолдол бүртгэгдсэн нь амбулаторийн нийт өсгөврийн 54.1%–ийг эзэлж байна.

ХЭТ–т *S. aureus* (16,294) болон *Shigella spp* (2698) илүүтэй өсгөвөрлөгдсөн байна. Ялангуяа *Shigella spp*–ийн нийт тохиолдлын 87.7% нь гэдэсний халдварын тасгуудад бүртгэгдсэн нь онцлог юм. ЭЭТ–т өсгөвөрлөгдсөн нийт тохиолдлын дунд *A. baumannii* (576)–ийн тохиолдол хамгийн их хувийг эзэлж байна.

Өөрөөр хэлбэл өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн бүтцэд *E. coli* болон *S. aureus* нь амбулатори болон ХЭТ–уудад зонхилон тохиолдож байна. Харин *A. baumannii* нь ЭЭТ–ийн халдварын шалтгаанд томоохон байр эзэлж байгаа тул энэ чиглэлээр халдварын сэргийлэлт, хяналтыг эрчимжүүлэх шаардлагатай байна.



Зураг 3.2–1 Өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тоо, тасаг нэгжийн төрлөөр (2019–2023 он)

Хүснэгт 3.2–1 Өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тоо, тасаг нэгжийн төрлөөр (2019–2023 он)

Төрөл зүйл	Амбулатори	ХЭТ	ЭЭТ	Нийт
<i>Staphylococcus aureus</i>	12915	16294	979	30188
<i>Streptococcus pneumoniae</i>	68	35	13	116
<i>Enterococcus faecalis</i>	834	843	127	1804
<i>Enterococcus faecium</i>	112	138	86	336
<i>Acinetobacter baumannii</i>	312	446	576	1334
<i>Pseudomonas aeruginosa</i>	436	487	126	1049
<i>Escherichia coli</i>	20251	9915	626	30792
<i>Klebsiella pneumoniae</i>	1928	1280	328	3536
<i>Salmonella spp</i>	164	668	5	837
<i>Shigella spp</i>	368	2698	11	3077
<i>Haemophilus influenzae</i>	5	1	1	7
<i>Neisseria meningitidis</i>		4		4
<b>Нийт</b>	<b>37393</b>	<b>32809</b>	<b>2878</b>	<b>73080</b>

### 3.2.1 Цусны сорьцноос өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)


2019–2023 оны хугацаанд цусны өсгөврийн шинжилгээгээр нийт 797 тохиолдолд эмгэгтөрөгч илэрч, өсгөвөрлөгдсөн байна. Өсгөвөрлөгдсөн нийт тохиолдлыг тусламж үйлчилгээ үзүүлж буй тасгийн төрлөөр ангилан үзвэл 538 (67.5%) нь ХЭТ, 207 (26.0%) нь ЭЭТ-аас, 52 (6.5%) нь амбулаторид тус тус бүртгэгдсэн байна.

Цусны өсгөврөөс илэрсэн эмгэгтөрөгчдийн бүтцийг авч үзэхэд *S. aureus* зонхилон тохиолдож байна. *S. aureus*-ийн нийт 413 омог өсгөвөрлөгдсөн нь цусны өсгөврөөс илэрсэн нийт эмгэгтөрөгчийн 51.8%-ийг бүрдүүлж байна. Үүний дийлэнх нь буюу 289 тохиолдол ХЭТ, 86 нь ЭЭТ-д бүртгэгджээ.

*E. coli*-ийн нийт 182 тохиолдол (22.8%) илэрсэн бөгөөд үүний 140 нь ХЭТ-т, 33 нь ЭЭТ-д оношлогдсон байна. *K. pneumoniae*-ийн хувьд нийт 70 тохиолдол (8.8%) бүртгэгдсэнээс 51 нь ХЭТ, 16 нь ЭЭТ-д тус тус өсгөвөрлөгдсөн байна.

Бусад эмгэгтөрөгчдийн дотор *A. baumannii* (47), *E. faecium* (27), *E. faecalis* (25) зэрэг харьцангуй цөөн тохиолдолд илэрсэн байна.

Цусны өсгөврөөс эмгэгтөрөгч илэрсэн тохиолдлын 67.5% нь ХЭТ бөгөөд *S. aureus* болон *E. coli* хамгийн их, харин ЭЭТ-д *A. baumannii* (34) болон *S. aureus* (86) илүүтэй өсгөвөрлөгдсөн байна.



Зураг 3.2–2 Цусны сорьцноос өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)


Хүснэгт 3.2–2 Цусны өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)

Төрөл зүйл	Амбулатори	ХЭТ	ЭЭТ	Нийт
<i>Staphylococcus aureus</i>	38	289	86	413
<i>Streptococcus pneumoniae</i>		7	6	13
<i>Enterococcus faecalis</i>		13	12	25
<i>Enterococcus faecium</i>	1	8	18	27
<i>Acinetobacter baumannii</i>	1	12	34	47
<i>Pseudomonas aeruginosa</i>		14	2	16
<i>Escherichia coli</i>	9	140	33	182
<i>Klebsiella pneumoniae</i>	3	51	16	70
<i>Salmonella spp</i>		1		1
<i>Haemophilus influenzae</i>		1		1
<i>Neisseria meningitidis</i>		2		2
<b>Нийт</b>	<b>52</b>	<b>538</b>	<b>207</b>	<b>797</b>

### 3.2.2 Тархи нугасны шингэний сорьцноос өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)

2019–2023 оны хугацаанд ТНШ-ий өсгөврийн шинжилгээний эерэг тохиолдол 47 байснаас дийлэнх буюу 31 (66.0%) нь ХЭТ, 10 (21.3%) нь ЭЭТ, харин 6 (12.7%) нь амбулаторийн тасгаас байжээ. ТНШ-ий өсгөврөөс илэрсэн эмгэгтөрөгчдийн бүтцийг авч үзэхэд *S. aureus* зонхилон тохиолдож байна. *S. aureus*-ийн нийт 19 тохиолдол (нийт тохиолдлын 40.4%) илэрсэн нь хамгийн өндөр тархалттай эмгэгтөрөгч болсон байна. Үүний 12 нь ХЭТ-аас, 5 нь ЭЭТ-аас, 2 нь амбулаториор үйлчлүүлэгчдээс өсгөвөрлөгдсөн байна. Мөн *K. pneumoniae* болон *S. pneumoniae*-ийн тус бүр 7 тохиолдол (14.9%) илэрсний *K. pneumoniae*-ийн 6 тохиолдол нь ХЭТ, *S. pneumoniae*-ийн 3 тохиолдол нь ХЭТ-т бүртгэгдсэн байна.

Харин *E. coli*-ийн нийт 5 тохиолдол (10.6%) бүртгэгдсэнээс 4 нь ХЭТ-т илэрсэн байна. Бусад эмгэгтөрөгчдийн хувьд *E. faecalis*-ийн 4 тохиолдол, *N. meningitidis*-ийн 2 тохиолдол, *A. baumannii*-ийн 2 тохиолдол болон *H. influenzae*-ийн 1 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.



Зураг 3.2–3 ТНШ-ий өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)


Хүснэгт 3.2–3 ТНШ-ий өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)

Төрөл зүйл	Амбулатори	ХЭТ	ЭЭТ	Нийт
<i>Staphylococcus aureus</i>	2	12	5	19
<i>Streptococcus pneumoniae</i>	2	3	2	7
<i>Enterococcus faecalis</i>		4		4
<i>Acinetobacter baumannii</i>	1		1	2
<i>Escherichia coli</i>		4	1	5
<i>Klebsiella pneumoniae</i>		6	1	7
<i>Haemophilus influenzae</i>	1			1
<i>Neisseria meningitidis</i>		2		2
<b>Нийт</b>	<b>6</b>	<b>31</b>	<b>10</b>	<b>47</b>

### 3.2.3 Шээсний сорьцоос өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)

2019–2023 оны хугацаанд шээсний өсгөврийн шинжилгээгээр нийт 31497 тохиолдолд эмгэгтөрөгч өсгөвөрлөгдсөн байна. Өсгөвөрлөгдсөн нийт тохиолдлын дийлэнх буюу 22155 (70.3%) нь амбулаторид, 8719 (27.7%) нь ХЭТ–т, 623 (2.0%) нь ЭЭТ–т тус тус бүртгэгджээ.

Өсгөвөрлөгдсөн нийт эмгэгтөрөгчдийн бүтцийг авч үзэхэд *E. coli* давамгайлж байна. Нийт 27282 тохиолдол буюу шээсний өсгөврөөс илэрсэн нийт эмгэгтөрөгчийн 86.6%–ийг *E. coli* эзэлж байна. Үүний 19545 нь амбулаторид, 7356 нь ХЭТ–т тус тус бүртгэгджээ. *K. pneumoniae* –ийн хувьд шээсний сорьцоос нийт 1976 тохиолдол (6.3%) бүртгэгдсэнээс 1394 нь амбулаторид, 518 нь ХЭТ–т илэрчээ. Харин *E. Faecalis*–ийн нийт 1387 тохиолдол (4.4%) бүртгэгдсэн нь гурав дахь гол үүсгэгч болж байна. Бусад эмгэгтөрөгчдийн хувьд харьцангуй бага буюу *P. aeruginosa* –ийн 370 тохиолдол, *E. faecium*–ийн 256 тохиолдол, болон *A. baumannii* –ийн 226 тохиолдол илэрсэн байна.



Зураг 3.2–4 Шээсний өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)


Хүснэгт 3.2–4 Шээсний өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)

Төрөл зүйл	Амбулатори	ХЭТ	ЭЭТ	Нийт
<i>Enterococcus faecalis</i>	727	589	71	1387
<i>Enterococcus faecium</i>	99	103	54	256
<i>Acinetobacter baumannii</i>	156	49	21	226
<i>Pseudomonas aeruginosa</i>	234	104	32	370
<i>Escherichia coli</i>	19545	7356	381	27282
<i>Klebsiella pneumoniae</i>	1394	518	64	1976
<b>Нийт</b>	<b>22155</b>	<b>8719</b>	<b>623</b>	<b>31497</b>

### 3.2.4 Өтгөний сорьцоос өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)

Өтгөний өсгөврийн шинжилгээгээр нийт 3913 тохиолдолд эмгэгтөрөгч илэрсэн ба шинжилгээнд хамрагдсан нийт тохиолдлын 3365 (86.0%) нь ХЭТ–т, 532 (13.6%) нь амбулаторид, 16 (0.4%) нь ЭЭТ–т байна. Өтгөний өсгөврөөс илэрсэн эмгэгтөрөгчдийн 78.6% нь *Shigella spp*, 21.4% нь *Salmonella spp*-ийн төрлийн бактериуд байна.

*Shigella spp*-ийн нийт 3077 тохиолдол илэрснээс *Shigella flexneri* –ийн 2673 (нийт тохиолдлын 68.3%) тохиолдол байна. Эдгээр тохиолдлын дийлэнх нь ХЭТ–аас өсгөвөрлөгджээ. *Salmonella spp*-ийн нийт 836 тохиолдол илэрснээс *Salmonella enteritidis* –ийн 357 (9.1%) тохиолдол байна.




Зураг 3.2-5 Өтгөний өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)

Хүснэгт 3.2-5 Өтгөний өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)

Төрөл зүйл	Амбулатори	ХЭТ	ЭЭТ	Нийт
<i>Salmonella bovismorbificans</i>		10		10
<i>Salmonella enteritidis</i>	10	345	2	357
<i>Salmonella spp</i>	150	274	2	426
<i>Salmonella typhimurium</i>	4	38	1	43
<i>Shigella boydii</i>	35	100	1	136
<i>Shigella flexneri</i>	239	2424	10	2673
<i>Shigella sonnei</i>		2		2
<i>Shigella spp</i>	94	172		266
<b>Нийт</b>	<b>532</b>	<b>3365</b>	<b>16</b>	<b>3913</b>

Зураг 3.2-6 Өтгөний өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн *Shigella spp*, *Salmonella spp*-ийн тоо (2019–2023 он)




Хүснэгт 3.2–6 Өтгөний өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн *Shigella* spp, *Salmonella* spp-ийн тоо (2019–2023 он)

Төрөл зүйл	Амбулатори	ХЭТ	ЭЭТ	Нийт
<i>Salmonella</i> spp	164	667	5	836
<i>Shigella</i> spp	368	2698	11	3077
<b>Нийт</b>	<b>532</b>	<b>3365</b>	<b>16</b>	<b>3913</b>

### 3.2.5 Амьсгалын доод замын сорьцны өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)

2019–2023 оны хугацаанд АДЗ-ын сорьцноос нийт 3122 тохиолдолд бичил биетэн өсгөвөрлөгдсөн байна. Өсгөвөрлөгдсөн нийт тохиолдлыг тасгийн төрлөөр ангилан үзвэл 1253 (40.1%) нь амбулатори, 1064 (34.1%) нь ХЭТ-т, 805 (25.8%) нь ЭЭТ тус тус бүртгэгджээ.

АДЗ-ын сорьцоос илэрсэн эмгэгтөрөгчдийн бүтцийг авч үзэхэд *S. aureus* нийт тохиолдлын 1133 (36.3%) үүний 553 нь амбулаторид, 434 нь ХЭТ-т, 146 нь ЭЭТ-т бүртгэгджээ. *K. pneumoniae* 812 (26.0%) бүртгэгдсэнээс 383 нь амбулаторид, 277 нь ХЭТ-т, 152 нь ЭЭТ-т тус тус өсгөвөрлөгджээ. *A. baumannii* нийт 645 тохиолдол (20.7%) илэрсэн бөгөөд энэ нь ЭЭТ-ийн халдварын шалтгааны дийлэнх хувийг бүрдүүлж байна. Тодруулбал, *A. baumannii*-ийн нийт тохиолдлын 63.1% нь ЭЭТ-т бүртгэгдсэн нь онцлог юм.



Зураг 3.2–7 АДЗ-ын өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)


Хүснэгт 3.2–7 АДЗ-ын өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)

Төрөл зүйл	Амбулатори	ХЭТ	ЭЭТ	Нийт
<i>Staphylococcus aureus</i>	553	434	146	1133
<i>Streptococcus pneumoniae</i>	66	25	5	96
<i>Acinetobacter baumannii</i>	93	145	407	645
<i>Pseudomonas aeruginosa</i>	70	103	46	219
<i>Escherichia coli</i>	84	80	48	212
<i>Klebsiella pneumoniae</i>	383	277	152	812
<i>Haemophilus influenzae</i>	4	1	0	5
<b>Нийт</b>	<b>1253</b>	<b>1064</b>	<b>805</b>	<b>3122</b>

### 3.2.6 Шархны сорьцоос өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)

2019–2023 оны хугацаанд шархны сорьцоос нийт 33,704 тохиолдолд эмгэгтөрөгч өсгөвөрлөгдсөн байна. Шинжилгээг тасгийн төрлөөр нь ангилан үзвэл 19,092 (56.6%) нь ХЭТ-т, 13,395 (39.7%) нь амбулаторид, 1,217 (3.6%) нь ЭЭТ-аас тус тус бүртгэгджээ.

Шархны сорьцоос өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчдийн бүтцийг авч үзэхэд *S. aureus* давамгайлж байна. *S. aureus* нийт 28,623 өсгөвөрлөгдсөн нь шархны халдвар нийт тохиолдлын 84.9%-ийг бүрдүүлж байгаа бөгөөд *E. coli*-ийн нийт 3,111 тохиолдол 9.2%-ийг эзэлж байна. Мөн *K. pneumoniae* 671 (2.0%) болон *P. aeruginosa*-ийн 444 (1.3%) тохиолдол тус тус бүртгэгджээ. *A. baumannii*-ийн 414 тохиолдол илэрсний ихэнх нь ХЭТ болон ЭЭТ-т бүртгэгдсэн байна.



Зураг 3.2–8 Шархны өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)

Хүснэгт 3.2–8 Шархны өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн эмгэгтөрөгчийн тархалт ба бүтэц (2019–2023 он)

Төрөл зүйл	Амбулатори	ХЭТ	ЭЭТ	Нийт
<i>Staphylococcus aureus</i>	12322	15559	742	28623
<i>Enterococcus faecalis</i>	107	237	44	388
<i>Enterococcus faecium</i>	12	27	14	53
<i>Acinetobacter baumannii</i>	61	240	113	414
<i>Pseudomonas aeruginosa</i>	132	266	46	444
<i>Escherichia coli</i>	613	2335	163	3111
<i>Klebsiella pneumoniae</i>	148	428	95	671
<b>Нийт</b>	<b>13395</b>	<b>19092</b>	<b>1217</b>	<b>33704</b>

### 3.3 ЭМНЭЛЗҮЙН СОРЬЦНООС ӨСГӨВӨРЛӨСӨН ЭМГЭГТӨРӨГЧДИЙН ТЭСВЭРЖИЛТ

#### 3.3.1 *Staphylococcus aureus* –ийн антибиотикийн тэсвэржилтийн байдал (2019–2023 он)


2019–2023 оны хооронд эмнэлзүйн сорьцноос өсгөвөрлөсөн *S. aureus*–ын антибиотикийн тэсвэржилтийн байдалд дүн шинжилгээ хийхэд метициллин тэсвэртэй *S. aureus* (МТСА)–ийг тодорхойлох үндсэн маркер болох оксациллин болон цефокситины тэсвэржилт тасралтгүй өсөх хандлагатай байв. Тухайлбал, оксациллины тэсвэржилт 2019 онд 71.5% байсан бол 2023 онд 84.3% болж өссөн, цефокситины тэсвэржилт 42.6%–аас 71.7% хүртэл мэдэгдэхүйц нэмэгджээ.

Хүснэгт 3.3–1 *S. aureus* –ийн антибиотикийн тэсвэржилтийн байдал (2019–2023 он)

Антибиотик	Нийт (R%) (n/N)					
	2019	2020	2021	2022	2023	
<b>Oxacillin</b>	71.5% (754/1054)	79.4% (1189/1498)	86.2% (1062/1232)	82.6% (1026/1242)	84.3% (2504/2969)	
<b>Cefoxitin</b>	42.6% (461/1082)	77.2% (4237/5487)	73.8% (2891/3920)	71.8% (2870/3998)	71.7% (4663/6499)	
<b>Erythromycin</b>	55.1% (757/1373)	48.7% (3094/6356)	43.3% (1993/4605)	43.1% (1882/4368)	42.9% (3562/8310)	
<b>Tetracycline</b>	3.6% (43/1188)	4.1% (107/2590)	4.0% (83/2101)	3.5% (67/1922)	5.7% (253/4401)	
<b>Doxycycline</b>	– (3/3)	0.2% (1/423)	0.0% (0/132)	2.7% (20/754)	6.7% (137/2030)	
<b>Trimethoprim–sulfamethoxazole</b>	32.3% (443/1373)	17.3% (666/3839)	33.9% (856/2527)	29.6% (707/2390)	41.0% (2003/4881)	
<b>Chloramphenicol</b>	30.4% (123/404)	20.5% (104/508)	15.9% (251/1578)	15.3% (198/1295)	14.2% (270/1907)	
<b>Ciprofloxacin</b>	61.7% (1234/2001)	76.1% (4272/5614)	74.5% (3371/4524)	74.3% (3210/4318)	78.1% (5890/7546)	
<b>Moxifloxacin</b>	6.3% (8/127)	– (4/21)	48.6% (154/317)	43.9% (159/362)	75.3% (651/864)	
<b>Ofloxacin</b>	10.1% (9/89)	40.3% (25/62)	31.5% (23/73)	66.3% (199/300)	79.4% (421/530)	
<b>Gentamicin</b>	26.7% (503/1883)	41.6% (2193/5274)	53.5% (1894/3542)	49.6% (1581/3186)	43.8% (2560/5850)	
<b>Rifampin</b>	0.50% (5/1082)	1.20% (12/1042)	2.50% (23/919)	2.60% (35/1357)	2.20% (68/3035)	
<b>Tigecycline</b>	0.0% (0/181)	– (0/9)	0.0% (0/63)	5.1% (20/389)	10.4% (85/815)	
<b>Quinupristin–dalfopristin</b>	0.0% (0/806)	0.1% (1/746)	0.0% (0/540)	0.0% (0/408)	0.2% (2/991)	

Тайлбар: Өгөгдлийг тэсвэржилтийн хувь болон нийт шинжилсэн сорьцын тоонд ногдох тэсвэртэй омгийн тоогоор (R%, n/N) илэрхийлэв. Статистикийн үнэн зөв байдлыг хангах үүднээс жил бүрийн сорьцын тоо 30–аас бага (n < 30) тохиолдолд тэсвэржилтийн хувийг тооцоолоогүй бөгөөд зураасаар (–) тэмдэглэв.

Бусад антибиотикийн хувьд ципрофлоксацины тэсвэржилтийн хувь жил бүр тогтмол өсөж 2023 онд 78.1%–д хүрсэн бол, макролидын бүлгийн эритромицины тэсвэржилт 42.9% – 55.1% хооронд хэлбэлзсэн хувьтай байлаа. Гентамицины тэсвэржилт 2019 онд 26.7% байснаа 2021 онд 53.5% хүртэл ихсэж, 2022, 2023 онд 49.6% болон 43.8% болсон байна. Харин квинупристин–дальфопристиний тэсвэржилт 5%–аас бага байна.



Зураг 3.3–1 *S. aureus* –ийн антибиотикийн тэсвэржилтийн хувь (2019–2023 он)

2019–2023 оны хооронд эмнэлзүйн сорьцноос өсгөвөрлөсөн *S. aureus*–ийн ванкомицин, клиндамициний мэдрэг чанарыг тодорхойлсон шинжилгээний үр дүн байсан хэдий ч эцсийн дүн шинжилгээнээс хассан болно. Учир нь CLSI M100 удирдамжийн дагуу ванкомициныг заавал өсөлт саатуулах бага тун (ӨСБТ буюу MIC) тодорхойлох аргаар баталгаажуулах шаардлагатай байдаг. Харин клиндамициний өдөөгддөг тэсвэржилт (Inducible clindamycin resistance)–ийг илрүүлэх “D тест”–ийн шинжилгээ хийгдсэн эсэх мэдээлэл байхгүй тул клиндамициний тэсвэржилтийн хувийг тодорхойлох боломжгүй гэж үзлээ.

Мөн удирдамжийн дагуу линезолид тэсвэртэй гарсан тохиолдолд халдварын хяналтын багт мэдэгдэж, ХӨСҮТ–ийн лавлагаа лаборатори руу сорьцыг илгээн баталгаажуулах ёстой байдаг ч энэхүү шаардлага хангагдаагүй байна. Иймд цаашид эмнэлзүйн лабораториуд дээр дурдсан тохиолдлуудад шинжилгээг давтан шалгаж, өсгөврийг хадгалан холбогдох журмын дагуу лавлагаа лабораторид илгээж баталгаажуулж байхыг зөвлөж байна.

### Тасгийн төрлөөр харьцуулсан дүн

Тэсвэржилтийн байдал нь амбулатори, ХЭТ болон ЭЭТ харилцан адилгүй байна. МТСА–ыг илрүүлэх гол арга болох цефокситины тэсвэржилт амбулаторийн сорьцуудад 2019 онд 50.6% байснаас 2023 онд 72.0% болж эрс өссөн бол, ЭЭТ–т 78.3% хүртэл өндөр тархалттай хэвээр байна. Ципрофлоксацины тэсвэржилт бүх тасагт өндөр байж, 2023 онд амбулаторид 76.2%, ХЭТ–т 79.9%–д хүрчээ.

Тасгуудын хоорондох хамгийн их ялгаа гентамицины хувьд ажиглагдсан бөгөөд 2023 оны байдлаар ХЭТ–т 31.9% байсан бол ЭЭТ–т 70.5% буюу 2 дахин өндөр болсон байв. Триметоприм–сульфаметоксазол (TMP–SMX)–ын тэсвэржилт хэвтэн эмчлүүлэгсдийн дунд 2019 онд 30.9% байсан ба 2023 онд 44.4% болж нэмэгдсэн байна. Квинупристин–дальфопристины тэсвэржилт харьцангуй бага байгаа хэдий ч тэсвэржилт илэрч эхэлсэн нь анхаарал татаж байна. ЭЭТ–ийн өсгөврийн тоо харьцангуй бага байгаа нь тус тасагт тэсвэржилтийн бодит тархалтыг харах боломжийг хязгаарлаж байна.

Хүснэгт 3.3–2 S. aureus-ийн антибиотикийн тэсвэржилтийн байдал, тасгийн төрлөөр (2019–2023 он)

Антибиотик	Амбулатори					ХЭТ					ЗЭТ				
	2019	2020	2021	2022	2023	2019	2020	2021	2022	2023	2019	2020	2021	2022	2023
<b>Penicillin</b>	98.8% (159/161)	97.8% (1043/1067)	98.4% (1093/1111)	95.7% (754/788)	97.8% (1530/1564)	99.0% (857/866)	98.6% (1818/1843)	99.1% (1414/1427)	97.2% (1170/1204)	98.1% (1834/1870)	–	100.0% (72/72)	100.0% (128/128)	98.9% (91/92)	100.0% (121/121)
<b>Oxacillin</b>	83.3% (165/198)	78.9% (105/133)	96.4% (295/306)	83.5% (182/218)	89.4% (639/715)	68.8% (586/852)	79.4% (1056/1330)	81.8% (703/859)	81.9% (810/989)	82.5% (1834/2222)	–	80.0% (28/35)	95.5% (64/67)	97.1% (34/35)	96.9% (31/32)
<b>Cefoxitin</b>	50.6% (287/567)	78.3% (1944/2483)	72.5% (1381/1906)	70.5% (1442/2045)	72.0% (2343/3256)	34.0% (150/441)	77.1% (2140/2775)	74.7% (1353/1812)	72.8% (1334/1833)	71.1% (2150/3026)	32.4% (24/74)	66.8% (153/229)	77.7% (157/202)	78.3% (94/120)	78.3% (170/217)
<b>Gentamicin</b>	51.9% (314/605)	49.7% (1213/2439)	66.6% (1146/1722)	66.7% (894/1340)	58.6% (1450/2475)	14.1% (171/1212)	33.9% (905/2666)	38.6% (646/1672)	36.6% (654/1789)	31.9% (1048/3287)	27.3% (19/66)	44.4% (75/169)	68.9% (102/148)	57.9% (33/57)	70.5% (62/88)
<b>Erythromycin</b>	56.9% (244/429)	47.8% (1168/2441)	49.0% (1032/2107)	48.3% (924/1913)	47.8% (1675/3503)	49.7% (543/1093)	48.4% (1836/3794)	42.4% (1032/2435)	42.9% (1062/2475)	43.8% (2059/4703)	63.6% (35/55)	67.0% (144/215)	53.4% (117/219)	47.8% (64/134)	54.3% (120/221)
<b>Tetracycline</b>	5.5% (15/274)	4.4% (49/1104)	3.8% (33/860)	5.2% (33/635)	7.2% (111/1547)	3.1% (28/906)	3.9% (57/1468)	4.2% (50/1195)	2.7% (34/1255)	5.0% (140/2791)	–	–	0.0% (0/46)	0.0% (0/32)	3.2% (2/63)
<b>Doxycycline</b>	100.0% (3/3)	–	–	3.1% (4/129)	16.7% (78/467)	–	0.3% (1/395)	0.0% (0/120)	2.6% (16/620)	3.4% (53/1537)	–	0.0% (0/2)	–	–	–
<b>Ciprofloxacin</b>	69.9% (538/770)	69.6% (1746/2510)	72.9% (1695/2326)	74.3% (1483/1996)	76.2% (2315/3038)	60.1% (774/1287)	72.8% (2552/3507)	72.4% (1877/2591)	76.9% (1946/2532)	79.9% (3675/4600)	32.4% (24/74)	58.7% (111/189)	71.9% (166/231)	75.6% (99/131)	78.6% (180/229)
<b>Trimethoprim-sulfamethoxazole</b>	35.3% (131/371)	17.2% (295/1711)	37.1% (397/1069)	31.9% (253/793)	35.9% (616/1717)	30.9% (303/979)	17.5% (361/2059)	31.4% (439/1397)	28.8% (438/1523)	44.4% (1360/3064)	39.1% (9/23)	14.5% (10/69)	32.8% (20/61)	21.6% (16/74)	27.0% (27/100)
<b>Chloramphenicol</b>	24.5% (35/143)	19.3% (64/332)	18.5% (148/798)	23.3% (126/541)	14.2% (170/1197)	33.6% (71/211)	20.2% (33/163)	13.7% (95/691)	9.4% (66/704)	13.7% (94/685)	34.0% (17/50)	53.8% (7/13)	9.0% (8/89)	12.0% (6/50)	24.0% (6/25)
<b>Rifampin</b>	1.4% (3/210)	1.9% (2/108)	6.1% (10/164)	3.9% (8/206)	3.4% (26/762)	0.2% (2/864)	0.9% (8/920)	1.4% (10/723)	2.2% (25/1116)	1.8% (41/2239)	0.0% (0/8)	14.3% (2/14)	9.4% (3/32)	5.7% (2/35)	2.9% (1/34)
<b>Quinupristin-dalfopristin</b>	0.0% (0/67)	0.0% (0/38)	0.0% (0/41)	0.0% (0/34)	0.0% (0/154)	0.0% (0/739)	0.1% (1/706)	0.0% (0/492)	0.0% (0/368)	0.2% (2/831)	–	–	–	–	–

### Сорьцны төрлөөр харьцуулсан дүн

2019–2023 оны хооронд өсгөврийн шинжилгээнээс өсгөвөрлөсөн *S. aureus*-ийн тоо болон тэдгээрийн антибиотикийн тэсвэржилтийн байдлыг Сорьцны төрлөөр харьцуулсан дүн Хүснэгт 3.3–3–т үзүүлэв.

Сорьцны төрлөөс хамаарч *S. aureus*-ийн тархалт болон тэсвэржилтийн түвшин ялгаатай дүр зураг харагдаж байна. Энэ хугацаанд *S. aureus* нь шархны өсгөвөрт хамгийн түгээмэл ( $n=8,291$ ) илэрч байгаа бол цэрний ( $n=463$ ) болон цусны ( $n=147$ ) өсгөвөрт харьцангуй бага бүртгэгджээ.

2019–2023 оны хооронд цусны өсгөвөрлөх шинжилгээнээс илэрсэн *S. aureus*-ийн антибиотикийн тэсвэржилтийг авч үзэхэд өргөн хэрэглэдэг эмүүдийн тэсвэржилт өндөр байна. Цефокситинд тэсвэртэй (МТСА) омгийн эзлэх хувь 2020 онд хамгийн өндөр буюу 85.2% (46/54) байсан бол 2023 онд 63.9% (85/133) болж буурах хандлага үзүүлсэн байна. Ципрофлоксациний тэсвэржилт 2020 онд 86.4% (38/44) байснаа 2021–2023 онуудад 59.8–65.4% (83/127) байна. Гентамицин болон эритромициний тэсвэржилт 2023 оны байдлаар харгалзах 51.5% болон 43.9%–тай байна. Анхаарал татсан үзүүлэлт нь триметоприм–сульфаметоксазолын тэсвэржилт 2020 онд 7.7% (3/39) байснаас 2023 онд 36.5% (27/74) болж огцом өссөн байна. Харин *S. aureus* нь тетрациклинд харьцангуй мэдрэг хэвээр буюу 2023 онд тэсвэржилтийн хувь 11.1% (6/54) буюу хамгийн бага хувьтай гарлаа.

Сорьцны төрлөөс хамаарсан тэсвэржилтийн хувийг харьцуулахад шархны сорьцноос өсгөвөрлөсөн омгууд хамгийн өндөр тэсвэржилттэй, олон эмэнд тэсвэртэй байх хандлагатай байна. Ялангуяа цефокситины тэсвэржилт шархны сорьцонд 72.1% (4243/5887) байгаа нь цэрний сорьцон дахь 68.5% (292/426) болон цусны сорьцон дахь 63.9% (85/133) үзүүлэлтээс өндөр байна. Мөн ципрофлоксацины тэсвэржилт шархнаас өсгөвөрлөсөн омогт 78.7% (5502/6993) байгаа нь цэр 72.2% (273/378) болон цусны 65.4% (83/127) өсгөврийн шинжилгээнээс өсгөвөрлөсөн омгийн тэсвэржилтийн хувиас их байна. Энэ нь арьс, зөөлөн эдийн халдварын үед фторхинолоны бүлгийн антибиотикийн эмчилгээний үр дүн бага байхад нөлөөлнө.


Харин амьсгалын замын сорьц буюу цэрний өсгөвөрт гентамицины тэсвэржилт 57.1% (190/333) байгаа нь цус 51.5% (35/68) болон шархны 42.8% (2316/5405) өсгөврийн шинжилгээний тэсвэржилтийн хувиас их байгаа нь онцлог юм. Түүнчлэн триметоприм–сульфаметоксазолын тэсвэржилт цэрний сорьцонд 42.1% (106/252) байгаа нь цус 36.5% (27/74) болон шархны 34.6% (857/2477) өсгөврийн шинжилгээнээс өсгөвөрлөсөн омгийн тэсвэржилтийн хувиас өндөр байна. Харин эритромицины тэсвэржилт сорьцны төрлөөс үл хамааран харьцангуй ижил буюу цусны сорьцонд 43.9% (61/139), шархны сорьцонд 43.1% (3316/7699), цэрний сорьцонд 40.4% (170/421) байна.

Хүснэгт 3.3–3 S. aureus-ийн антибиотикийн тэсвэржилтийн байдал (2019–2023 он)

Антибиотик	Цус					Цэр					Шарх				
	2019	2020	2021	2022	2023	2019	2020	2021	2022	2023	2019	2020	2021	2022	2023
	n=21	n=57	n=109	n=78	n=147	n=50	n=123	n=271	n=202	n=463	n=2022	n=7025	n=4974	n=4946	n=8291
Penicillin	– (8/8)	100.0% (33/33)	95.8% (69/72)	97.8% (45/46)	97.2% (70/72)	– (23/24)	94.5% (69/73)	99.5% (212/213)	99.9% (138/147)	96.6% (283/293)	99.0% (990/1000)	98.4% (2828/2873)	98.9% (2352/2379)	96.9% (1829/1888)	98.2% (3130/3188)
Oxacillin	– (1/2)	– (1/2)	– (12/13)	– (11/13)	– (19/22)	– (2/8)	– (4/8)	98.3% (114/116)	– (25/29)	97.1% (132/136)	71.9% (748/1041)	79.6% (1183/1486)	84.8% (933/1100)	82.5% (990/1200)	83.7% (2348/2804)
Cefoxitin	– (5/18)	85.2% (46/54)	71.2% (57/80)	77.3% (51/66)	63.9% (65/133)	– (2/10)	79.5% (58/73)	73.5% (136/185)	47.2% (75/159)	68.5% (292/426)	47.7% (434/909)	78.1% (4088/5232)	74.6% (2685/3601)	72.7% (2700/3713)	72.1% (4243/5887)
Gentamicin	– (11/19)	42.2% (19/45)	64.7% (44/68)	61.0% (25/41)	51.5% (35/68)	31.1% (14/45)	47.1% (48/102)	70.0% (156/223)	68.7% (92/134)	57.1% (190/333)	27.4% (457/1668)	41.7% (2084/4999)	52.4% (1675/3197)	48.3% (1436/2976)	42.8% (2316/5405)
Erythromycin	– (9/13)	45.1% (23/51)	47.9% (45/94)	46.2% (30/65)	43.9% (61/139)	42.9% (18/42)	56.9% (58/102)	49.5% (94/190)	50.0% (85/170)	40.4% (170/421)	53.0% (646/1220)	48.0% (2931/6109)	42.7% (1830/4288)	42.8% (1756/4104)	43.1% (3316/7699)
Tetracycline	– (0/11)	– (1/6)	– (0/26)	– (1/18)	11.1% (6/54)	– (2/10)	– (2/15)	5.6% (4/72)	– (1/17)	7.6% (17/224)	3.5% (41/1165)	4.0% (104/2568)	4.0% (79/2000)	3.4% (65/1886)	5.6% (230/4123)
Doxycycline	–	– (0/1)	–	– (0/5)	– (1/14)	–	– (0/2)	– (0/1)	– (2/5)	8.6% (3/35)	– (3/3)	0.2% (1/420)	0.0% (0/131)	2.4% (18/741)	6.9% (133/1934)
Ciprofloxacin	– (14/21)	86.4% (38/44)	59.8% (49/82)	60.7% (37/61)	65.4% (83/127)	62.8% (27/43)	72.2% (65/90)	60.8% (124/204)	70.1% (108/154)	72.2% (273/378)	65.5% (1173/1792)	77.0% (4141/5380)	76.1% (3166/4185)	74.7% (3022/4044)	78.7% (5502/6993)
Clindamycin	– (2/3)	43.9% (18/41)	32.8% (21/64)	37.5% (21/56)	25.0% (28/112)	– (2/12)	60.7% (34/56)	37.9% (50/132)	33.3% (27/81)	26.7% (73/273)	43.5% (517/1188)	39.5% (1477/3739)	32.6% (1045/3209)	32.4% (1041/3209)	29.4% (1856/6312)
Trimethoprim-sulfamethoxazole	– (7/10)	7.7% (3/39)	11.8% (4/34)	31.6% (12/38)	36.5% (27/74)	– (2/7)	15.8% (9/57)	62.2% (46/74)	68.8% (64/93)	42.1% (106/252)	36.3% (162/446)	14.8% (376/2540)	32.8% (526/1605)	30.6% (359/1175)	34.6% (857/2477)
Chloramphenicol	– (3/13)	– (0/1)	17.0% (9/53)	– (5/23)	18.2% (6/33)	20.0% (7/35)	22.7% (10/44)	20.3% (12/59)	28.3% (30/106)	18.1% (21/116)	29.0% (64/221)	20.0% (91/455)	15.6% (227/1458)	13.5% (157/1159)	13.8% (243/1758)
Rifampin	– (0/2)	– (0/1)	– (2/5)	– (1/14)	– (1/20)	– (0/10)	– (1/7)	12.5% (7/56)	9.1% (4/44)	7.7% (13/169)	0.3% (3/1068)	1.1% (11/1034)	1.4% (12/856)	2.3% (30/1298)	1.9% (54/2846)
Quinupristin-dalfopristin	– (0/2)	–	– (0/1)	– (0/3)	– (0/4)	– (0/7)	– (0/3)	– (0/11)	– (0/4)	– (0/19)	0.0% (0/797)	0.1% (1/743)	0.0% (0/401)	0.0% (0/401)	0.2% (2/968)

Тайлбар: Өнгө: ■ ≥70% өндөр ■ 40–69% дунд ■ 10–39% бага ■ <10% маш бага – (n/N) n<30 үед хувийг тооцоолгүй; Тэсвэржилтийн хувийг ЭПСИ-ийн дагуу завхэн тэсвэртэй (R) харилгаар тооцсон; тэсвэржилтийн хувийг тооцоход дунд мэдрэг (I)-ийг оруулаагүй;


Цусны өсгөврийн шинжилгээгээр өсгөвөрлөсөн *S. aureus*-ийн олон эмэнд тэсвэртэй (MDR) байдлыг 2019–өөс 2023 онд харьцуулан үзэхэд үжил халдварын үед тэсвэржилт ихсэж байгаа нь тодорхойлогдов. Гурваас дээш бүлгийн антибиотикт тэсвэртэй MDR омгууд тасралтгүй илэрсээр байгаагаас гадна зөвхөн 1–2 антибиотикт л мэдрэг үлдсэн хэт олон эмэнд тэсвэртэй (XDR) омгууд болон бүх эмэнд тэсвэртэй (PDR) омог илэрч байгаа нь эмнэлзүйд бэрхшээл учруулж болох тул анхаарах шаардлагатай байна.



Зураг 3.3–2 Цуснаас өсгөвөрлөсөн *S. aureus*-ийн антибиотикийн тэсвэржилтийн хандлага (2019–2023 он)

Тайлбар: ALL S: Бүх төрлийн антибиотикийн бүлэгт мэдрэг; 1–2 DR: 1–2 антибиотикийн бүлэгт л мэдрэг бус (тэсвэртэй); MDR: 3 ба түүнээс дээш антибиотикийн бүлэгт мэдрэг бус (олон эмэнд тэсвэртэй); XDR: Зөвхөн 1–2 антибиотикийн бүлэгт мэдрэг, бусад бүх бүлэгт мэдрэг бус (хэт олон эмэнд тэсвэртэй); PDR (бүх эмэнд тэсвэртэй): мэдрэг чанарыг тодорхойлсон бүх эмэнд тэсвэртэй

Шархны халдварын үед антибиотикийн тэсвэржилтийн нөхцөл байдал үжил халдвараас тэсвэржилтийн нөхцөл байдал илүү хүнд байна. XDR буюу хэт олон эмэнд тэсвэржилттэй омгийн эзлэх хувь маш өндөр байна. 2019 онд 24% байсан бол 2020 онд 45% хүрч, 2023 онд 29% буюу нийт шархны халдварын бараг гуравны нэг нь эмчилгээний сонголтгүй шахам түвшинд хүрсэн байна. PDR буюу бүх эмэнд тэсвэртэй омог жил бүр бүртгэгдэж, 2021 онд 7%, 2022 онд бүр 9%–д хүрсэн нь маш түгшүүртэй үзүүлэлт юм. Хэдийгээр 2023 онд 3% болж буурсан ч үжил халдвартай (1%) харьцуулахад 3 дахин их байна. Шархны халдвар үүсгэсэн *S. aureus*-ийн омог дунд бүх эмэнд мэдрэг (ALL S) омог 5 жилийн туршид ердөө 6% – 11%–ийн хооронд маш бага хэмжээнд хэлбэлзжээ.




Зураг 3.3–3 Шархнаас өсгөвөрлөсөн *S. aureus*-ийн антибиотикийн тэсвэржилтийн хандлага (2019–2023 он)

Тайлбар: ALL S: Бүх төрлийн антибиотикийн бүлэгт мэдрэг; 1–2 DR: 1–2 антибиотикийн бүлэгт л мэдрэг бус (тэсвэртэй); MDR: 3 ба түүнээс дээш антибиотикийн бүлэгт мэдрэг бус (олон эмэнд тэсвэртэй); XDR: Зөвхөн 1–2 антибиотикийн бүлэгт мэдрэг, бусад бүх бүлэгт мэдрэг бус (хэт олон эмэнд тэсвэртэй); PDR (бүх эмэнд тэсвэртэй): мэдрэг чанарыг тодорхойлсон бүх эмэнд тэсвэртэй

Амьсгалын доод замын халдварыг төлөөлөх цэрний сорьцод антибиотикийн тэсвэржилт маш өндөр байгаа бөгөөд эмчилгээний сонголт эрс хязгаарлагдмал түвшинд байна. 2019 болон 2022 онуудад хэт олон эмэнд тэсвэртэй (XDR) буюу зөвхөн 1–2 бүлгийн антибиотикт л мэдрэг үлдсэн омгууд давамгайлж, нийт сорьцын 58.3% болон 46.8%–ийг тус тус эзэлж байжээ. Энэ нь амьсгалын замын халдварын үед түгээмэл хэрэглэдэг антибиотикүүд огт үйлчлэхгүй байх өндөр эрсдэлтэйг харуулж байна. Мөн бүх эмэнд тэсвэртэй (PDR) омог 2020 онд огцом өсөж 21.1%–д хүрсэн байгаа нь зайлшгүй анхаарал хандуулах шаардлагатай үзүүлэлт юм. Хэдийгээр энэхүү үзүүлэлт 2023 онд 4.3% болж буурсан ч амьсгалын замын халдварын үед эмчлэх боломжгүй (untreatable) халдварын тохиолдол байсаар байгааг харуулж байна. (Энэхүү 2020 оны огцом өсөлт нь Ковид–19 цар тахлын үеийн антибиотикийн хэт хэрэглээ эсвэл эрчимт эмчилгээний тасаг дахь халдварын дэгдэлттэй холбоотой байх өндөр магадлалтай). Мөн түүнчлэн 2023 онд XDR омгийн эзлэх хувь 23.8% болж буурсан боловч гурваас дээш бүлгийн эмэнд тэсвэртэй MDR омгийн эзлэх хувь 2019 онд 4.2% байснаа тасралтгүй өссөөр 2023 онд 41.0%–д хүрсэн байна.

Бүх эмэнд мэдрэг (ALL S) омгийн эзлэх хувь 5 жилийн туршид ердөө 6.3% – 9.5%–ийн хооронд маш бага хэмжээнд хэлбэлзсэн нь таамаг эмчилгээнд эхний сонголтын антибиотикүүдийг хэрэглэх боломж хязгаарлагдмал болсныг нотолж байна.

Өөрөөр хэлбэл цэрний өсгөвөрт олон эмэнд тэсвэртэй (MDR) болон хэт олон эмэнд тэсвэртэй (XDR) үүсгэгчид нийт тохиолдлын 64% – 80%–ийг тогтмол эзэлж байгаа нь амьсгалын замын халдварын үеийн эмчилгээний үр дүнгүй байх эрсдэлийг эрс нэмэгдүүлж байна. Ялангуяа 2020 онд PDR омог 21.1%–д хүрч байсан нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой уушгины хатгаа болон амьсгалын аппараттай холбоотой уушгины хатгааны үед халдварын сэргийлэлт, хяналтыг сайжруулж, антибиотикийн зохистой хэрэглээг хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.



Зураг 3.3–4 Цэрнээс өсгөвөрлөсөн *S. aureus*-ийн антибиотикийн тэсвэржилтийн хандлага (2019–2023 он)

*Тайлбар:* ALL S: Бүх төрлийн антибиотикийн бүлэгт мэдрэг; 1–2 DR: 1–2 антибиотикийн бүлэгт л мэдрэг бус (тэсвэртэй); MDR: 3 ба түүнээс дээш антибиотикийн бүлэгт мэдрэг бус (олон эмэнд тэсвэртэй); XDR: Зөвхөн 1–2 антибиотикийн бүлэгт мэдрэг, бусад бүх бүлэгт мэдрэг бус (хэт олон эмэнд тэсвэртэй); PDR (бүх эмэнд тэсвэртэй): мэдрэг чанарыг тодорхойлсон бүх эмэнд тэсвэртэй

Цэрний өсгөвөртэй харьцуулахад үжил халдварын үед XDR болон PDR омгийн эзлэх хувь харьцангуй бага байгаа хэдий ч, олон эмэнд тэсвэртэй (MDR) байдал 50%–аас дээш давамгайлж байгаа нь таамаг эмчилгээний зохистой сонгох удирдамжийг шинэчлэх, ялангуяа халдварын сэргийлэлт хяналтын дэглэмийг эрс сайжруулах шаардлагатай байна.

### Өвөрмөц тэсвэржилтийн төрлөөр харьцуулсан дүн

2019–2023 оны хугацаанд *S. aureus* нь шархны сорьцонд хамгийн их тоогоор (2023 онд 5,845 МТСА, 2,061 МТСА–бус) өсгөвөрлөгдсөн бол цэр (301 МТСА, 136 МТСА–бус) болон цусны сорьцонд (90 МТСА, 50 МТСА–бус) харьцангуй бага тохиолдол бүртгэгдсэн байна. Нийт өсгөвөрлөгдсөн омгуудын дунд МТСА–ийн эзлэх хувь шархны сорьцонд хамгийн өндөр байгаа нь анхаарал татаж байна.

МТСА–ын ципрофлоксацины тэсвэржилт сорьцны төрлөөс үл хамааран өндөр байна. МТСА–ын 91.2% (3074/3369), цэрний МТСА–ын 89.6% (225/251) нь ципрофлоксацинд тэсвэртэй байна. Цуснаас өсгөвөрлөсөн МТСА гентамицинд 79.4% (27/34) тэсвэртэй буюу хамгийн өндөр, цэрэнд 70.8% (153/216) байгаа бол шархнаас өсгөвөрлөсөнд 74.4% (1752/2356) байна.

Харин эритромицины тэсвэржилт шарханд 50.3%, цусанд 57.5%, цэрэнд 48.0% байгаа нь сорьцны төрлөөс хамаарахгүй ойролцоо хувийг эзэлж байна. Триметоприм–сульфаметоксазолын хувьд тэсвэржилт шархнаас өсгөвөрлөгдсөн МТСА–д 37.6% (736/1956), цэрэнд 44.8% (90/201), харин цуснаас өсгөвөрлөгдсөн МТСА–д хамгийн өндөр буюу 88.9% (64/72) байна. Цуснаас өсгөвөрлөгдсөн МТСА–ын 44.2% (23/52), цэрний МТСА–ын 21.2% (11/52), шархны МТСА–ын 14.6% (148/1016) нь тус тус хлорамфениколд тэсвэртэй байна.

Шарх, цэр болон цуснаас өсгөвөрлөгдсөн МТСА омгууд ципрофлоксацин, гентамицин болон эритромицинд, цуснаас өсгөвөрлөгдсөн МТСА омгууд триметоприм–сульфаметоксазолд маш өндөр (88.9%) тэсвэртэй байгаа нь системийн халдварын үед эмчилгээний сонголтыг нэн хязгаарлагдмал болгож байна.

Хүснэгт 3.3–4 Цуснаас өсгөвөрлөсөн *S. aureus*-ийн антибиотикийн тэсвэржилт, метициллийн тэсвэржилтээр (2019–2023 он)

Антибиотик	МТСА					МТСА–бус				
	2019	2020	2021	2022	2023	2019	2020	2021	2022	2023
	n=6	n=46	n=58	n=59	n=90	n=14	n=8	n=24	n=17	n=50
Penicillin	–	–	–	–	–	– (4/4)	– (4/4)	– (13/13)	– (11/11)	– (18/20)
Oxacillin	–	–	–	–	–	–	– (0/1)	– (1/1)	–	– (0/1)
Cefoxitin	–	–	–	–	–	– (0/13)	– (0/8)	– (0/23)	– (0/15)	0.0% (0/48)
Gentamicin	– (4/4)	47.5% (19/40)	83.9% (26/31)	– (17/23)	79.4% (27/34)	– (6/12)	– (0/5)	– (5/17)	– (5/8)	– (4/23)
Erythromycin	– (2/2)	50.0% (21/42)	52.3% (23/44)	59.0% (23/39)	57.5% (46/80)	– (6/8)	– (1/8)	– (6/21)	– (2/15)	20.8% (10/48)
Tetracycline	– (0/2)	– (1/6)	– (0/18)	– (1/8)	11.4% (4/35)	– (0/6)	–	– (0/7)	– (0/1)	– (2/13)
Doxycycline	–	– (0/1)	–	– (0/3)	– (0/4)	–	–	–	–	– (1/5)
Ciprofloxacin	–	–	–	–	–	–	–	–	–	–
Trimethoprim– sulfamethoxazole	– (5/5)	97.2% (35/36)	94.3% (33/35)	74.4% (29/39)	88.9% (64/72)	– (7/13)	– (0/5)	– (2/19)	– (0/11)	23.3% (10/43)
Chloramphenicol	– (2/3)	8.8% (3/34)	– (4/20)	– (7/26)	44.2% (23/52)	– (4/6)	– (0/5)	– (0/11)	– (4/9)	– (4/22)
Rifampin	– (0/2)	–	– (0/23)	– (4/16)	– (1/15)	– (2/10)	–	– (5/13)	– (1/7)	– (3/16)
Quinupristin– dalfopristin	–	–	– (2/4)	– (0/3)	– (1/12)	–	– (0/1)	–	– (1/1)	– (0/2)

Тайлбар: Өнгө: ■ ≥70% өндөр ■ 40–69% дунд ■ 10–39% бага ■ <10% маш бага – (n/N) n<30 үед хувийг тооцоогүй; МТСА–ын тодорхойлолт: Зөвхөн цефокситинд (FOX) тэсвэртэй (R) байх; дунд мэдрэг (I) омгуудыг МТСА–бус гэж ангилсан; Тэсвэржилтийн хувийг ЭЛСИ–ийн дагуу зөвхөн тэсвэртэй (R) хариугаар тооцсон; тэсвэржилтийн хувийг тооцоход дунд мэдрэг (I)–ийг оруулаагүй;

Хүснэгт 3.3–5 Цэрнээс өсгөвөрлөсөн *S. aureus*-ын антибиотикийн тэсвэржилт, метициллиний тэсвэржилтээр (2019–2023 он)

Антибиотик	МТСА					МТСА–бус				
	2019	2020	2021	2022	2023	2019	2020	2021	2022	2023
	n=4	n=59	n=150	n=90	n=301	n=14	n=18	n=51	n=87	n=136
Penicillin	–	–	–	–	–	– (2/2)	– (5/5)	100.0% (40/40)	88.4% (61/69)	88.3% (68/77)
Oxacillin	–	–	–	–	–	–	– (0/1)	– (16/16)	– (0/1)	– (3/5)
Cefoxitin	–	–	–	–	–	– (0/8)	– (0/15)	0.0% (0/49)	0.0% (0/84)	0.0% (0/134)
Gentamicin	–	43.1% (22/51)	89.7% (104/116)	84.6% (33/39)	70.8% (153/216)	– (2/7)	– (1/12)	40.5% (17/42)	69.2% (45/65)	16.9% (14/83)
Erythromycin	–	66.7% (30/45)	58.4% (52/89)	53.1% (34/64)	48.0% (131/273)	– (2/4)	– (2/12)	– (11/23)	49.3% (36/73)	16.8% (19/113)
Tetracycline	–	– (1/7)	3.3% (2/61)	– (0/4)	5.5% (10/182)	–	– (1/4)	– (1/5)	–	– (1/27)
Doxycycline	–	– (0/1)	–	– (2/2)	– (2/17)	–	– (0/1)	–	–	– (1/11)
Ciprofloxacin	–	100.0% (39/39)	93.8% (91/97)	83.0% (44/53)	89.6% (225/251)	– (5/8)	– (3/13)	12.9% (4/31)	59.0% (36/61)	28.4% (27/95)
Trimethoprim–sulfamethoxazole	– (0/2)	13.0% (6/46)	65.1% (41/63)	44.4% (16/36)	44.8% (90/201)	– (0/2)	– (3/10)	– (1/4)	86.7% (39/45)	26.1% (12/46)
Chloramphenicol	–	– (1/3)	– (2/15)	– (6/27)	21.2% (11/52)	– (3/5)	–	– (3/8)	24.2% (15/62)	12.2% (6/49)
Rifampin	–	– (1/3)	12.8% (6/47)	– (1/16)	5.7% (8/140)	– (0/2)	–	– (0/2)	– (0/10)	– (1/16)
Quinupristin–dalfopristin	–	–	– (0/7)	–	– (0/13)	–	–	– (0/2)	–	– (0/2)

Тайлбар: Өнгө: ■ ≥70% өндөр ■ 40–69% дунд ■ 10–39% бага ■ <10% маш бага – (n/N) n<30 үед хувийг тооцоогүй; МТСА–ийн тодорхойлолт: Зөвхөн цефокситинд (FOX) тэсвэртэй (R) байх; дунд мэдрэг (I) омгуудыг МТСА–бус гэж ангилсан; Тэсвэржилтийн хувийг ЭЛСИ–ийн дагуу зөвхөн тэсвэртэй (R) хариугаар тооцсон; тэсвэржилтийн хувийг тооцоход дунд мэдрэг (I)–ийг оруулаагүй;

Хүснэгт 3.3–6 Шархнаас өсгөвөрлөсөн *S. aureus*-ын антибиотикийн тэсвэржилт, метициллиний тэсвэржилтээр (2019–2023 он)

Антибиотик	МТСА					МТСА–бус				
	2019	2020	2021	2022	2023	2019	2020	2021	2022	2023
	n=1116	n=4868	n=3289	n=3541	n=5845	n=765	n=1370	n=1077	n=1207	n=2061
Penicillin	–	–	–	–	–	97.7% (42/43)	95.0% (345/363)	97.5% (311/319)	88.1% (304/345)	91.1% (482/529)
Oxacillin	–	–	–	–	–	– (0/3)	1.3% (1/76)	– (11/17)	– (9/24)	11.9% (5/42)
Cefoxitin	–	–	–	–	–	0.0% (0/475)	0.0% (0/1144)	0.0% (0/916)	0.0% (0/1013)	0.0% (0/1644)
Gentamicin	80.5% (248/308)	60.0% (1697/2828)	79.8% (1217/1525)	80.7% (1134/1406)	74.4% (1752/2356)	30.2% (114/377)	8.6% (72/836)	26.5% (143/539)	33.3% (163/490)	38.9% (357/918)
Erythromycin	80.3% (118/147)	56.7% (1989/3505)	50.8% (1120/2205)	51.1% (1126/2203)	50.3% (2001/3978)	59.5% (69/116)	16.3% (154/945)	17.8% (142/796)	25.8% (208/805)	29.8% (438/1472)
Tetracycline	2.9% (4/140)	4.1% (50/1214)	4.9% (49/1007)	4.8% (30/630)	8.0% (143/1778)	7.9% (5/63)	6.3% (21/331)	1.7% (4/241)	4.7% (11/233)	11.9% (40/336)
Doxycycline	– (2/2)	0.0% (0/185)	– (0/26)	11.2% (17/152)	15.2% (70/461)	–	0.0% (0/45)	– (0/7)	1.9% (1/54)	18.1% (60/332)
Ciprofloxacin	95.2% (357/375)	96.4% (2902/3010)	96.3% (2189/2274)	86.7% (1811/2090)	91.2% (3074/3369)	28.8% (121/420)	14.6% (127/871)	20.6% (157/763)	33.6% (258/768)	46.0% (596/1296)
Trimethoprim–sulfamethoxazole	44.0% (84/191)	17.0% (329/1934)	40.3% (470/1165)	31.0% (286/924)	37.6% (736/1956)	18.6% (32/172)	7.2% (39/539)	15.7% (49/313)	28.7% (56/195)	21.9% (102/466)
Chloramphenicol	13.5% (5/37)	9.5% (8/84)	10.6% (86/813)	13.0% (100/768)	14.6% (148/1016)	32.8% (39/119)	– (4/17)	11.8% (33/280)	12.7% (44/347)	12.4% (84/677)
Rifampin	0.0% (0/134)	8.3% (4/48)	5.7% (8/141)	9.0% (15/166)	7.0% (52/738)	0.0% (0/33)	– (2/14)	– (0/4)	0.0% (0/99)	0.0% (0/114)
Quinupristin–dalfopristin	–	–	– (0/23)	–	0.0% (0/105)	–	–	– (0/5)	–	– (0/18)

Тайлбар: Өнгө: ■ ≥70% өндөр ■ 40–69% дунд ■ 10–39% бага ■ <10% маш бага – (n/N) n<30 үед хувийг тооцоогүй; МТСА–ын тодорхойлолт: Зөвхөн цефокситинд (FOX) тэсвэртэй (R) байх; дунд мэдрэг (I) омгуудыг МТСА–бус гэж ангилсан; Тэсвэржилтийн хувийг ЭЛСИ–ийн дагуу зөвхөн тэсвэртэй (R) хариугаар тооцсон; тэсвэржилтийн хувийг тооцоход дунд мэдрэг (I)–ийг оруулаагүй;

2019–2023 оны хооронд өсгөвөрлөгдсөн *S. aureus*-ыг олон эмийн тэсвэржилтийн (MDR, XDR, PDR) хэв шинжийг харьцуулан үзэхэд МТСА омгуудын дунд олон эмэнд тэсвэртэй (MDR) омгийн эзлэх хувь 2019 онд 31.7% байсан бол 2023 онд 50.5% (2357/4663) болж мэдэгдэхүйц өссөн байна. Хэт олон эмэнд тэсвэртэй (XDR) хэлбэрийн тархалт 32.5% – 43.6%-ийн хооронд хэлбэлзэж байна. Ялангуяа бүх эмэнд тэсвэртэй (PDR) омгууд жил бүр бүртгэгдэж байгаа бөгөөд 2022 онд хамгийн өндөр буюу 6.8% (194/2870)-д хүрсэн нь стафилококкийн халдварын үед эмчилгээний сонголт улам хязгаарлагдмал болох эрсдэлийг харуулж байна.

МТСА-бус омгуудын хувьд тэсвэржилт харьцангуй бага байгаа ч бүх антибиотикт мэдрэг (ALL S) омгийн эзлэх хувь 2020 онд 34.3% байсан бол 2023 онд 24.7% болж буурсан байна. Мөн 1–2 бүлгийн антибиотикт тэсвэртэй (1–2 DR) хэлбэр давамгайлж (45.0% – 55.7%) байгаа ч олон эмэнд тэсвэртэй (MDR) омгийн хувь 2020 онд 7.9% байснаас 2023 онд 21.0% болж, бараг 3 дахин өссөн нь анхаарал татаж байна. Хэт олон эмэнд тэсвэртэй (XDR) хэлбэр МТСА-бус омгуудын дунд 2022 онд 10.3%-д хүрч байсан бол 2023 онд 5.3% байна.

